



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/203

Улаанбаатар хот

Г Монгол улсын их сургуулийн
сургалтын журам шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

- “Монгол улсын их сургуулийн сургалтын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
- Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба (Ч.Ундрям), Төгсөлтийн дараах сургууль (Б.Отгонтөгс), Мэдээллийн технологийн алба (А.Баатарбилэг), Санхүү, эдийн засгийн хэлтэс (Б.Энхцэцэг), бүрэлдэхүүн сургуулийн захидал, сургалтын албаны эрхлэгч наарт үүрэг болгосугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2012 оны 652 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Монгол улсын их сургуулийн бакалаврын сургалтын журам” болон 2012 оны 425 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол улсын их сургуулийн төгсөлтийн дараах сургуулийн сургалтын журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Р.БАТ-ЭРДЭНЭ



My document Tushaal 2015 June

20151180



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуульд нийцүүлэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журмыг үндэслэн Монгол Улсын Их Сургуульд (цаашид МУИС гэнэ) дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө.

1.2. МУИС-ийн багш, суралцагч (оюутан, магистрант, докторант), эрдэм шинжилгээний ажилтан, бусад сургалтанд оролцогч этгээд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Бакалаврын зэрэг олгох сургалтын зорилго нь бүрэн дунд боловсролтой иргэнийг нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай бүтээлч, логик сэтгэлгээтэй, санаачлагатай, шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг эзэмшсэн, ёс зүйтэй, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай дээд боловсролтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

1.4. Магистрын зэрэг олгох сургалтын зорилго нь бакалаврын боловсролтой иргэнд сургалт, эрдэм шинжилгээ, уйлдвэрлэл, инновацийн хүрээнд мэргэжлийн чадварлаг боловсрол эзэмшүүлэх, эрдэм шинжилгээний удирдагч, зөвлөхийн удирдлагаар судалгаа шинжилгээний ажлыг ахисан түвшинд хийж, судалж буй асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлийн хувилбар боловсруулж, оновчтой сонголт хийхэд шаардагдах мэдлэг, чадвар, ёс суртахуун төлөвшүүлэхэд оршино.

1.5. Докторын зэрэг олгох сургалтын зорилго нь магистрын зэрэгтэй иргэнд бие даан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж, шинжлэх ухааны онол арга зүй, хэрэглээний хөгжилд хувь нэмэр оруулах, мэдлэгийг бүтээгдэхүүн болгон хөрвүүлэх, өөрийгөө болон бусдыг хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, ёс зүйг төлөвшүүлэхэд оршино.

1.6. МУИС-ийн бакалаврын зэрэг олгох сургалт нь өдөр, орой, эчнээ; магистрын зэрэг олгох сургалт нь өдөр, эчнээ; докторын зэрэг олгох сургалт нь өдөр, эчнээ, экстернат хэлбэртэй байна.

1.7. Бакалавр, магистр, докторын сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж болох ба цахим сургалттай холбоотой асуудлыг тусдаа журмаар зохицуулна.

1.8. Авьяаслаг, шилдэг суралцагчдад зориулсан тусгай хөтөлбөр /honours program/ хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусдаа журмаар зохицуулна.

1.9. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн захиргааны зөвлөл хэлэлцэж, захирал шийдвэр гаргана.

1.10. Журмын нэр томъёо

1.10.1. Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын гэсэн шатлалтай байна.

1.10.2. Дипломын ба бакалаврын зэрэг. Дээд боловсролын анхан шатны зэрэг бөгөөд эдгээр шатлалд суралцагчийг оюутан гэнэ.

1.10.3. Магистрын зэрэг. Дээд боловсролын бакалаврын дараах шатны зэрэг бөгөөд энэ шатлалд суралцагчийг магистрант гэнэ.

1.10.4. Докторын зэрэг. Дээд боловсролын магистрын дараах шатны зэрэг бөгөөд энэ шатлалд суралцагчийг докторант гэнэ.

1.10.5. Суралцагч. Оюутан, магистрант, докторантыг нийтэд нь суралцагч гэнэ.

1.10.6. *Хичээлийн цаг*. 50 минут байх ба хоёр цагийн хичээлийг дунд нь засварлагагүйгээр 90 минутад багтаан явуулж болно.

1.10.7. *Хөтөлбөр (Curriculum)*. Хоорондоо уялдаа холбоотой бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн (хөтөлбөрийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа) тодорхой шатны боловсролын зэрэг (degree) олгоход нийцүүлсэн суралцагчийн суралцах хөтөлбөр¹.

1.10.8. *Үндсэн мэргэжил (Major)*. Оюутны суралцах үндсэн чиглэл буюу тухайн шинжлэх ухааны тодорхой мэдлэг, чадвар, дадлыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр бакалаврын зэрэг олгох түвшинд эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.

1.10.9. *Хавсарга мэргэжил (Minor)*. Тодорхой болзол хангасан оюутанд суралцаж байгаа үндсэн мэргэжлийн зэрэгцээ өөр мэргэжлийн чиглэлээр системтэй мэдлэг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.

1.10.10. *Хос мэргэжил (Double Major)*. Тодорхой болзол хангасан оюутанд суралцаж байгаа үндсэн мэргэжил болон өөр чиглэлээр хоёр дахь мэргэжлийг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр.

1.10.11. *Гүнзгийрэн мэргэжлих (Track)*. Үндсэн мэргэжлийн дагуу гүнзгийрэн судлахад чиглэсэн багц хичээл.

1.10.12. *Сургалтын төлөвлөгөө*. Хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд судлах хичээлийн жагсаалт, агуулгын багтаамж, дараалал, дадлагын төрлийг тусгасан баримт бичиг.

1.10.13. *Хичээлийн хөтөлбөр*. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийн индекс, суралцагчийн эзэмшивэл зохих онолын ба практик мэдлэг, чадварын агуулга, сэдэвчилсэн төлөвлөгөө, үнэлгээ, арга зүй, тухайн хичээлийн багтаамж/багц цаг, ашиглавал зохих ном, суралцагчийн жагсаалтыг тодорхойлсон баримт бичиг.

1.10.14. *Хичээлийн индекс*. Хичээл тус бүр тусгай ялгах дугаар буюу индекстэй байна. Индекс нь тухайн шинжлэх ухааны салбарын ерөнхий нэрний эхний 4 үсэг (англиар) ба 3 оронтой тооноос бүрдэх бөгөөд эхний тоо нь уг хичээлийн түвшнийг, дараагийн хоёр тоо нь хичээлийн дугаар (хичээл хоорондын залгамж холбоо, дэс дарааллыг харгалzan тогтоогдсон)-ыг илэрхийлнэ. Үүнд:

001-099 дугаартай бол багц цаг олгохгүй хичээл

100-199 дугаартай бол ерөнхий суурь хичээл

200-499 дугаартай бол бакалаврын хөтөлбөрийн хичээл

500-599 дугаартай бол бакалавр болон магистрын хөтөлбөрийн суралцагчид хамт үзэж болох хичээл

600-699 дугаартай бол магистрын хөтөлбөрийн хичээл

700-799 дугаартай бол магистрын болон докторын оюутнуудын хамт үзэж болох хичээл

800-899 дугаартай бол докторын хичээл гэж ялгана.

МУИС-д заагдах хичээлүүдийн нэр, индекс давхцахгүй.

1.10.15. *Ерөнхий суурь (General Education) хичээл*. МУИС-ийн бакалаврын сургалтад тавигдах суурь шаардлагыг хангахад чиглэсэн, 1. Нийгэм, хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадвар 2. Эзэмсхэн мэдлэг, ур чадвараа амьдралд бүтээлчээр бодитой ашиглах дадал олгох үндсэн зорилго бүхий дээд боловсролын суурь судлагдахуун.

1.10.16. *Мэргэжлийн суурь (Core) хичээл*. Суралцагчид суралцах үндсэн чиглэлийнх нь шинжлэх ухааны суурь мэдлэгийг олгох, тухайн талбарт асуудал шийдвэрлэх,

¹ Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2014 оны 04 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалын хавсралт Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагаас

бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадварыг эзэмшиүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээл.

1.10.17. Мэргэжлийн хичээл (Major course). Тодорхой мэргэжлийн мэдлэг ур чадвар өгөхөд чиглэсэн, оюутанд шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэл, салбараар төвлөрч, гүнзгийрэн судлах боломж олгодог заавал болон сонгон судлах хичээл.

1.10.18. Заавал судлах (Compulsory) хичээл. Тухайн хөтөлбөрийн хувьд зайлшгүй судлах шаардлагатай хичээл.

1.10.19. Сонгон судлах (Elective) хичээл. Тухайн хөтөлбөрийн ~~сургалтын~~ төлөвлөгөөний бүлэг бүрээр авбал зохих багц цагийг судлах зорилгоор тодорхой бүлэг хичээлүүдээс суралцагч өөрөө сонгон судлах хичээл.

1.10.20. Залгамж (Prerequisite) хичээл. Тодорхой хичээлийг судлахаас өмнө амжилттай судалсан байвал зохих хичээл.

1.10.21. Зэрэгцүүлэн судлах (Corequisite) хичээл. Тухайн хичээлтэй зэрэгцүүлэн судлаж болох хичээл.

1.10.22. Чөлөөт сонголт (Free elective)-ын хичээл. Суралцагч өөрийн хүсэл, сонирхлоор сонгох боломжтой МУИС-аас санал болгож байгаа зэрэгцүүлэн судлах боломжтой бүх хичээл. Тухайн сонгож буй хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.

1.10.23. Лекцийн хичээл. Шинжлэх ухааны онолын суурь мэдлэгийг системтэй өгөх зорилготой багшийн тайлбарлан ярих болон сурган хүмүүжүүлэх бусад арга, хэрэгслийг хэрэглэж буй сургалтын хэлбэр юм.

1.10.24. Семинарийн хичээл. Онолын материалыг гүнзгийрүүлэн судлах, ерөнхийлөн дүгнэх, сэтгэхүйн шүүмжлэлт шинжийг хөгжүүлэх, мэдлэг хурумтлуулах, бүтээлч санаачлага болон ур чадварт суралцах, эргэцүүлэл хийх, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэй хамгаалах, илэрхийлэх дадал бүрэлдүүлэхэд чиглэсэн сургалтын хэлбэр юм.

1.10.25. Лабораторийн хичээл. Анги, лабораторид багшийн тусламжтайгаар суралцагч онолын мэдлэгийг бодит амьдралын үйл ажиллагаанд чиглэсэн туршилт дээр үндэслэн дадлага олгох буюу ажлын ур чадварыг эзэмшиүүлэх хичээл. Тус хичээл нь лаборатори доторх багаж төхөөрөмж хэрэглэх, лабораторийн тайлан бичих, өгөгдөл дун шинжилгээ хийх гэх мэт бие даалтын хэлбэрийг агуулж болно.

1.10.26. Дадлага². Хамтарсан сургалт, сургууль байгууллага хоорондын гэрээний дагуу олгож буй дадлага, дагалдан судлах зэрээр мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилготой. Дадлагын байранд 32 цаг, бие даан суралцахад 16 цаг зарцуулах нь нэг багц цагтай тэнцүү байна.

1.10.27. Багц цаг (Credit) нь боловсролын агуулгын багтаамжийг жиших нэгж бөгөөд суралцагчийн сурах ачаалал, багшийн сургалтын ажлын хэмжээ, сургалтын төлбөрийг тогтоох үндсэн хэмжүүр, дээд боловсролын зэрэг олгох сургалтад тавигдах нийтлэг шаардлага, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтын харилцааг зохицуулах үндэслэл болно. Нэг багц цагийн хэмжээ нь бакалаврын хөтөлбөрийн хувьд 48 цагтай, магистр, докторын хөтөлбөрийн хувьд 45 цагтай тус тус тэнцүү байна.

1.10.28. Хичээлийн багц цаг нь хичээлийн агуулгыг илэрхийлэх бүхэл тоо байх бөгөөд хэмжээ нь улиралд тухайн хичээлийг судлах цаг, хэлбэрээс хамаарна. Суралцагчийн нэг долоо хоногт сурах үйл ажиллагаанд зарцуулах дараах багц бүрийг нэг багц гэж тодорхойлно. Үнд:

- Лекц 1 цаг + суралцагчийн бие даан суралцах 2 цаг;
- Семинар 2 цаг + суралцагчийн бие даан суралцах 1 цаг;
- Лабораторийн хичээл 3 цаг;
- Дадлага, бакалаврын судалгааны ажил зэрэг сургалтын бусад хэлбэрээр оюутны сурах үйл ажиллагаанд зарцуулах 48 цагийг нэг багц цагтай дүйцүүлж тооцно.

² Дадлагын хичээлийг тусдаа журмаар зохицуулна.

1.10.29. *Суралцагчийн тухайн хичээлээр эзэмисэн мэдлэг, чадварын үнэлгээ.* Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн агуулгыг суралцагч хичээлийн явцад болон эцэст хэрхэн судалж эзэмшсэнийг харуулах нэгдсэн үзүүлэлт. Үнэлгээ нь хэмжилтийн хувьд “хувьчилсан оноо”, “үсгээр илтгэсэн дүн”, “тоогоор илтгэсэн дүн” гэсэн хэлбэртэй байна. Мөн “тооцов”, “үл тооцов” хэмээн үнэлж, харгалзан “S”, “U” гэсэн тэмдэглэгээг хэрэглэж болно.

1.10.30. *Хувьчилсан оноо.* Тухайн хичээлээр суралцагчийн хийж гүйцэтгэх ёстой болон бие даан суралцах үйл ажиллагааны биелэлт, эзэмшвэл зохих мэдлэг, чадварын түвшнийг 100% гэж үзэж, гүйцэтгэлийг нь түүнтэй харьцуулж үнэлсэн тоо. Үнэлгээ нь явцын (formative) ба улирлын (summative) үнэлгээ гэсэн хоёр хэсгээс тогтох бөгөөд тэдгээрийг бүхэл тоогоор илэрхийлнэ.

1.10.31. *Үсгээр илтгэсэн дүн* нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг илэрхийлэх A, A-, B, B-, C, C-, D, D-, F үсгээр тэмдэглэх үнэлгээ юм. Эдгээр үсгээр илтгэсэн дунд 4.0, 3.6, 3.1, 2.7, 2.3, 1.9, 1.4, 1.0, 0 гэсэн тоогоор илтгэсэн дүнг харгалзуулж болно.

1.10.32. *Явцын үнэлгээ.* Тухайн хичээлийн явцад суралцагч хөтөлбөрийн дагуу эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг хэрхэн эзэмшиж буйг үнэлж багш суралцагчийн сургах, сурах үйл ажиллагааг цаашид идэвхжүүлэх үзүүлэлт.

1.10.33. *Улирлын шалгалт.* Тухайн хичээлийг судалж дууссаны дараа суралцагч уг хичээлийн хөтөлбөрт заасан мэдлэг, ур чадварыг хэрхэн эзэмшсэнийг үнэлэх гол үзүүлэлт.

1.10.34. *Нэгдсэн шалгалт.* Боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг бүрэн судалсан суралцагчийн тухайн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар нь МУИС-ийн төгсөгчдөд тавих шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэх гол үзүүлэлт.

1.10.35. *Голч оноо.* Багц цаг бүхий хичээл бүрээр суралцагчийн авсан оноог багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хуваасан (арифметикийн жинлэсэн дундаж) үзүүлэлт.

1.10.36. *Голч дүн.* Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын тоон болон чанарын үнэлгээний нэгдэл бөгөөд голч онооны адил аргачлалаар бодно.

1.10.37. *Бакалаврын судалгааны ажил.* Бакалаврын хөтөлбөрийг биелүүлж буй оюутан тухайн үндсэн мэргэжлээр бакалаврын зэргийн дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардагдах мэдлэг, чадварыг эзэмшсэнээ баталгаажуулах, судалгаа шинжилгээний ажлын суурь мэдлэг, чадвараа хөгжүүлэх зорилгоор хийж болох судалгааны ажил юм.

1.10.38. *Магистрын судалгааны ажил.* Шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судалж туршилт, боловсруулалт, дүн шинжилгээг онол арга зүйн зохих түвшинд гүйцэтгэсэн судалгааны ажил юм.

1.10.39. *Докторын судалгааны ажил /диссертаци/.* Шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн, эсвэл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдсэн, урьд өмнө хийгдсэн мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, шүүмжлэлтэйгээр шинэлэг талыг нээн харуулсан, зохих загвар, шаардлагыг баримталсан, тухайн сэдвээр шинэ мэдлэг мэдээлэл, үндэслэл, онол практикийн дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний ажил юм.

1.10.40. *Сургалтын нэгдсэн алба.* МУИС-ийн сургалтын нэгдсэн төв алба.

1.10.41. *Сургалтын алба.* Бүрэлдэхүүн болон харьяа сургуулийн сургалтын алба.

1.10.42. *Элсэлтийн ерөнхий шалгалт.* Их, дээд сургуульд элсэхийг хүсэгчдийн мэдлэг, суралцах чадвар, авьяасыг тодорхойлон, тухайн их, дээд сургуулийн түвшин, элсэлтийн шаардлагыг хангасан суралцагчийг сургуулийн нөөц бололцоо, хүчин чадалд зохицсон хяналтын тоонд багтаан шалгаруулах зорилготой шалгалт юм. Уг шалгалтыг Боловсролын үнэлгээний төвөөс нэгдсэн журмаар зохион байгуулна.

1.10.43. *Элсэлтийн мэргэжлийн шалгалт.* Магистр, докторын болон бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхийг хүсэгчдийн мэдлэг, чадварыг тодорхойлох, цаашид тухайн

түвшинд суралцах болон судалгааны ажил хийх чадвартай эсэхийг тодорхойлох ерөнхий шалгалт юм.

Хоёр. Сургалтын удирдлага, зохион байгуулалт

2.1. МУИС-д Дээд боловсролын зэрэг олгох сургалтын ажлыг сургалтын нэгдсэн алба болон бүрэлдэхүүн, харья сургуулийн сургалтын алба Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмыг үйл ажиллагаандaa мөрдөн, удирдлагаар хангаж, зохион байгуулна.

2.2. Сургалтын нэгдсэн алба болон сургалтын алба нь МУИС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулах, суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажиллана.

2.3. Сургалтын нэгдсэн алба болон сургалтын алба дараах чиг үүрэгтэй. Үүнд:

2.3.1. Бакалавр, магистр, докторын сургалтын агуулга, хэлбэр, зохион байгуулалтын асуудлыг сургалтын стандартад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж, сургалтын тасралтгүй үйл ажиллагааг хангана.

2.3.2. Сургалтын чанарын удирдлагыг хэрэгжүүлж, сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн стандарт болон сургалтын технологийн хэрэгжилтэд мониторинг хийнэ.

2.3.3. Сургалтын үйл ажиллагаа болон суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

2.3.4. Багшийн сургалтын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянаж дүгнэлт хийнэ.

2.3.5. Цахим сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

2.3.6. Суралцагчийн сурах үйл ажиллагааг удирдан явуулах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

2.4. Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад МУИС-ийн холбогдох бусад нэгжийн оролцоо

2.4.1. Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад нэгжүүд уялдаа холбоотой, хариуцлагатай хамтран ажиллаж холбогдох дүрэм журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, эргэн тайлагнан ажиллана.

2.4.2. Бүрэлдэхүүн сургууль, тэнхим нь:

2.4.2.1. Багш нарын цагийн ачааллыг цаг тухайд нь сургалтын албанд гаргаж өгөх.

2.4.2.2. Баталсан хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалт явуулах;

2.4.2.3. Суралцагчдыг цаг хугацаанд нь бодитой үнэн, зөв үнэлж, дүнг цаг тухайд нь сургалтын мэдээллийн системд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих;

2.4.2.4. Хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг батлагдсан дүрэм журам, зааврын дагуу цаг тухайд нь боловсруулах, сайжруулах;

2.4.2.5. Эрдэм шинжилгээний хурал, их семинар зэрэг суралцагчдын дунд зохиох ажлыг хийх;

2.4.2.6. Хичээлийн хэвийн үйл ажиллагаа, багш профессорын хичээлийн болон зөвлөгөө өгөх цаг баримтлах явц, суралцагчийн хичээлийн оролцоонд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах;

2.4.2.7. Суралцагчдын дүнд статистик боловсруулалт хийж үр дүнд үндэслэн хичээлийн чанарт хяналт тавьж сайжруулах;

2.4.2.8. Багш, ажилтныг хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмж, бусад шаардлагатай эд зүйлсээр хангах зэрэг ажлыг хариуцан ажиллана.

2.4.3. Төгсөлтийн дараах сургууль нь:

2.4.3.1. Судалгааны үйл ажиллагааны хүрээнд магистрант, докторант оюутны эрдэм шинжилгээний ажлын чанар, үр дүнг сайжруулах, сургалтын болон судалгааны асистантшил (судалгааны сэдэвт ажил, төсөлд оролцуулж цалин урамшуулал олгох) хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.4.3.2. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх нийтлэг аргачлал боловсруулж, үнэлэх.

2.4.3.3. Магистрын ажил, докторын диссертацид УХД 0072 9104399 тавих стандарт боловсруулах, үнэлэх.

2.4.3.4. Докторын диссертаци хамгаалуулах зөвлөлтэй ажиллах бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавина.

2.4.4. Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс нь:

2.4.4.1. Эрдэм шинжилгээний хурал, их семинар зэрэг суралцагчдын дунд зохиогдох эрдэм шинжилгээний ажлыг холбогдох тэнхим, сургуулиудтай хамтран зохион байгуулах;

2.4.4.2. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг хэвлүүлж холбогдох нэгжүүдэд тараах зэрэг ажлуудыг хариуцна.

2.4.5. Санхүү, эдийн засгийн хэлтэс нь:

2.4.5.1. Сургалтын төлбөртэй холбоотой санал хүсэлтийг холбогдох дүрэм журмын дагуу шийдвэрлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах;

2.4.5.2. Сургалтын төлбөр, бүртгэлийн хураамжтай холбоотой мэдээллийг сургалтын мэдээллийн системд цаг тухайд нь оруулах;

2.4.5.3. Сургалтын төлбөр, бүртгэлийн хураамжтай холбоотой мэдээлэл, тайланг цаг тухайд нь гаргах;

2.4.5.4. Бүрэлдэхүүн сургууль хоорондын тооцоог хийх зэрэг ажлыг хариуцна.

2.4.6. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс нь:

2.4.6.1. МУИС-д суралцах гадаадын суралцагч, судлаачийн визтэй холбоотой асуудлыг хариуцаж цаг тухай бүрт холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;

2.4.6.2. Гадаад суралцагчийг шаардлагатай тохиолдолд тосч авах, оюутны байранд байрлуулах, зөвлөгөө өгөх зэрэг бусад үйлчилгээг үзүүлэх;

2.4.6.3. Гадаад суралцагчтай холбоотой мэдээллийг сургуулийн цахим хуудсанд байршуулж мэдээллийг тогтмол шинэчлэх зэрэг ажлыг хариуцна.

2.4.7. Мэдээллийн технологийн алба нь:

2.4.7.1. Сургалтын мэдээллийн системийг МУИС-ийн сургалтын шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлж сайжруулах;

2.4.7.2. Сургалтын мэдээллийн систем хэвийн ажиллах техник, технологийн нөхцлөөр хангах;

2.4.7.3. Сургалтын мэдээллийн систем, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах;

2.4.7.4. Сургалттай холбоотой статистик мэдээллээр хангах;

2.4.7.5. Харилцагч банкуудын онлайн төлбөрийн хэвийн үйл ажиллагааг санхүү, эдийн засгийн хэлтэстэй хамтран хянаж, гарсан асуудлыг тухай бүр шийдвэрлэх арга хэмжээ авах зэрэг ажлыг хариуцна.

2.4.8. Хангамж үйлчилгээний хэлтэс нь:

2.4.8.1. Анги танхимын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, сургалтын техник, тоног төхөөрөмжөөр хангаж хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

2.4.8.2. Сургуулийн эмнэлэг нь холбогдох дүрэм, журам, стандартын дагуу хичээлийн болон дотуур байрны ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэгийг тогтмол хийж, холбогдох ажилтнуудад заавар зөвлөгөө өгөх, МУИС-ийн багш, ажилтан, суралцагчдад эмнэлгийн анхан шатны тусlamж үзүүлнэ.

Гурав. Сургалтын хөтөлбөр

3.1. Хөтөлбөр нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан, дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байна.

3.2. Хөтөлбөр нь ерөнхий танилцуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа болон бусад нэмэлт мэдээллээс бүрдэнэ.

3.3. Хөтөлбөрийг бакалаврын түвшинд өдөр, орой, эчнээ хэлбэрээр үндсэн, хавсарга мэргэжил олгох, магистрын түвшинд өдөр, эчнээ хэлбэрээр судалгааны болон мэргэжлийн, докторын түвшинд өдөр, эчнээ, экстернат хэлбэрээр боловсруулна.

3.4. МУИС-д зөвхөн хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлагдсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.5. Сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах, өөрчлөх үйл явцыг МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмаар зохицуулна.

3.6. Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн агуулга, шаардлага

3.6.1. Дээд боловсролын Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь “ерөнхий суурь” (General education), “мэргэжлийн суурь” (Core), “мэргэжлийн” (Major) болон “чөлөөт сонголт” (Free elective) гэсэн бүтэцтэй байна.

Хөтөлбөрийн бүрдэл хэсгийн нэр	Тайлбар
Ерөнхий суурь (General education)-МУИС-ийн шаардлага	Дээд боловсролын үндэс буюу ойлгомжтой ярих, бичих; тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах; олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх; бусад мэргэжлийн хүмүүстэй үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх зорилготой заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
Мэргэжлийн суурь (Core)-Бүрэлдэхүүн сургуулийн шаардлага	Хөтөлбөрийн суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээлүүд байна.
Мэргэжлийн (Major)	Оюутны суралцах үндсэн мэргэжлийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг олгох, заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
Чөлөөт сонголт (Free elective)	Оюутан хавсарга болон хос мэргэжил эзэмших, магистрын хөтөлбөрийн зарим хичээлүүдийг судлах, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэхэд зориулагдсан хичээлүүд байна. Тухайн хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.

3.6.2. Бакалаврын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

	Бүрэлдэхүүн сургуулиуд			Х3С	Тайлбар /ХД0072 9104399
	ШУС, Орхон сургууль /хүмүүнлэгийн салбарын хөтөлбөр/	ХШУИС, БС, ОУХНУС, Орхон сургууль /бизнесийн хөтөлбөр/, Завхан сургууль			
Цутгуулах багц цаг					
Ерөнхий суурь	36	30	30		
Мэргэжлийн суурь	9	21	37		
Мэргэжлийн	60	54	68		
Чөлөөт сонголт	15	15	15		
НИЙТ	120	120	150		
Хавсарга мэргэжил	30	30	30		Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдээс бүрдэнэ.
Хос мэргэжил	69	75	105		Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдээс бүрдэнэ. Хоёр хөтөлбөрт ижил хичээл байвал аль алинд нь багц цагийг дүйцүүлэн тооцно.
Орой, эчнээ	69	75	105		Бакалаврын түвшинд эзэмшсэн мэргэжил болон суралцах мэргэжлээсээ хамааран суралцах багц цагийн хэмжээ өөрчлөгдж болно.

3.6.3. Бакалаврын өдрийн хөтөлбөрт суралцаж байгаа оюутан хөтөлбөрийн шаардлага хангасан тохиолдолд хос болон хавсарга мэргэжлээр мөн магистрын хөтөлбөрийн хичээлийг давхар сонгон суралцах боломжтой.

3.6.4. Бакалаврын орой, эчнээ хэлбэрээр суралцах дээд боловсролын бакалаврын зэрэгтэй иргэн бакалаврын түвшинд эзэмшсэн мэргэжил болон суралцах мэргэжлээсээ хамааран 3.6.2-т заасан багц цагийг цуглуулна.

3.6.5. Ерөнхий суурь хичээлийг боловсролын асуудал эрхэлсэн териийн захиргааны төв байгууллагын шаардлагад нийцүүлэн МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмын дагуу боловсруулж батлах бөгөөд дараах агуулгын чиглэлтэй байна. Үүнд:

Агуулгын чиглэл	Хүрэх үр дүн
1. Байгалийн ухаан	Байгалийн юмс үзэгдлийн мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг ойлгож тайлбарлах, мэдээлэлд шинжлэх ухаанчаар хандах, таамаглал дэвшүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвар эзэмшиүүлэх

2. Хүмүүнлэгийн ухаан	Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, уран зохиолын бичвэрт дүн шинжилгээ хийх чадвар, урлаг, гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, ёс зүйн үнэлэмжийг төлөвшүүлэх
3. Нийгмийн ухаан	Нийгэм, эдийн засаг, засаглал, соёлын олон талт байдал, хүмүүсийн харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлагад суралцуулах ⁹⁹
4. Иргэний боловсрол	Монголын түүх, соёл, улс төр, эдийн засаг, эрх зүй, хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах
5. Судалгаа шинжилгээний арга зүй	Тоон болон чанарын мэдээ баримтанд шинжилгээ хийж үнэлэх, логик сэтгэлгээ хөгжүүлэх, шалтгаан үр дагаварын холбоог тогтоох, процессийг загварчлах, асуудал тодорхойлох чадвар эзэмшүүлэх
6. Яриа, бичгийн ур чадвар	Яриа бичгийн өөрийгөө илэрхийлэх ур чадвар, эрдэм шинжилгээний бичлэгийн чадвар эзэмшүүлэх
7. Англи хэл, бусад хэл	Англи хэл (бусад хэл)-ээр мэргэжлийн эх сурвалжийг ашиглаж чаддаг байх, англи хэлний ярих, сонсох, унших, бичих ур чадварыг ахисан дунд түвшинд (upper intermediate) хүргэх
8. Биеийн тамир, эрүүл ахуйн	Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцах, эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусlamж үзүүлэх чадвар эзэмшүүлэх

3.6.6. Бүрэлдэхүүн сургуулийн ерөнхий суурь хичээлийн агуулгын чиглэл бүрээс үзэх багц цагийн хэмжээг МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо батална.

3.6.7. Оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулах бөгөөд тус журамд заасны дагуу ерөнхий суурийн хичээлийн тодорхой багц цагийг амжилттай судалсаны дараа мэргэжлийн хөтөлбөр сонгуулна.

3.6.8. Мэргэжлийн суурь (бүрэлдэхүүн сургуулийн шаардлага) хичээлийн багц цагт тухайн бүрэлдэхүүн сургуулийн санал болгож буй мэргэжлийн суурь мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй болон бусад суурь ойлголтыг өгөх зорилготой хичээлүүд орно.

3.6.9. Мэргэжлийн хичээл нь бакалаврын зэрэг олгох сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлээс бүрдэнэ. Мэргэжлийн хичээлийн багц цагт тухайн мэргэжлийн эзэмшвэл зохих шинжлэх ухааны мэдлэг, шаардагдах ур чадвар, дадлыг олгох заавал болон сонгон судлах хичээлүүд орно. Мэргэжлийн хичээлийг гүнзгийрэн судлах хэлбэрээр тэнхим санал болгож болно.

3.6.10. Чөлөөт сонголтын хичээлийн зорилго нь оюутан МУИС-д зааж байгаа нийт хичээлээс (залгамж холбоотой хичээл бол өмнөх хичээлийг нь үзсэн тохиолдолд) өөрийн сонирхлын дагуу чөлөөтэй сонгох боломжийг олгоход оршино.

3.6.11. Хавсарга мэргэжил олгох хөтөлбөр нь оюутныг хөдөлмөрийн зах зээлд давуу боломжтой оролцох нөхцлийг бүрдүүлэхэд чиглэх бөгөөд нийт 30 багц цаг (мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээл)-аас багагүй байна. Үндсэн мэргэжлийн зэрэгцээ хавсарга мэргэжил эзэмшиж байгаа оюутан бакалаврын зэрэг авахад шаардагдах нийт багц цаг 130 багагүй байна.

3.6.12. Хос мэргэжлийг эзэмшихдээ өөрийн сурч буй хөтөлбөрөөс гадна суралцах гэж буй хөтөлбөрийнхөө шаардлагыг хангаж, мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийг судална. Хос мэргэжил эзэмшиж байгаа оюутан хоёр бакалаврын зэрэг авахад шаардагдах нийт багц цагийн хэмжээ 174 багц цагаас багагүй байна.

3.6.13. Оюутан суралцаж буй үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, мэргэжлийн хичээлийн

багц цагийн 1/3-ийг амжилттай цуглуулсан, суралцсан хугацааны голч дун 2.6-аас дээш байх шаардлагыг хангасан тохиолдолд хос болон хавсарга мэргэжлээр суралцах хүсэлт гаргаж болно.

3.7. Магистрын зэрэг олгох хөтөлбөрийн агуулга, шаардлага

3.7.1. Дээд боловсролын магистрын зэрэг олгох хөтөлбөр нь мэргэжлийн суурь (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэшүүлэх (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), чөлөөт сонголт (тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, нэгжээс бусад тэнхим, салбар, их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгох хичээл), удирдагч багшийн удирдлага дор хийх эрдэм шинжилгээний ажил, дадлага, магистрын ажил гэсэн бүтэцтэй байна.

3.7.2. Магистрын хөтөлбөрүүдэд тухайн чиглэлээс өөр бакалаврын боловсрол эзэмшсэн элсэгчдэд зориулсан хөтөлбөр боловсруулж болно. Хөтөлбөрийн нийт багц цаг 15 хүртэл байх бөгөөд тухайн шинжлэх ухааны бакалаврын түвшний мэргэжлийн суурь хичээлүүдээс бүрдэнэ.

3.7.3. Судлаач болон мэргэжлийн магистрын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Судалгааны магистр	Мэргэжлийн магистр
Судалгааны арга зүй	3 багц цаг Судалгааны асуудал боловсруулах, таамаглал дэвшиүүлэх, харьцуулсан судалгаа анализ хийх, зүй тогтол, харилцаан хамаарлыг загварчлах, шинэ санаа гаргах, тоон болон чанарын шинжилгээ судалгаа хийх, дүгнэн боловсруулах, тайлاغнах ур чадвар	4 багц цагаас доошгүй, үүнээс 2 багц цагийн Харилцааны чадвар (харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мультимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах) эзэмшүүлэх хичээл, 2 баг цагийн Мэргэжлийн гадаад хэлний хичээл
Мэргэжлийн хичээл	6 багц цаг	12 багц цаг
Мэргэшүүлэх хичээл	12 багц цагаас доошгүй, үүнээс 3 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно, 4 багц цагийг магистрын ажилд зориулна	12 багц цаг Үүнээс 6 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно
Эрдэм шинжилгээний ажил	4 багц цаг	Мэргэжлийн дадлага 4 багц цаг (мэргэжлийн шалгалтанд бэлдэх модуль сургалтууд)
Магистрын ажил	5 багц цаг	0
		мэргэжлийн нэгдсэн шалгалт (Мэргэшсэн нягтлан бодогч, хуульчийн гэх мэт)
Нийт багц цаг	30 багц цаг	32 багц цаг

3.7.4. Магистрант нь нийт судлах багц цагийн 20 багц цагийг судалсаны дараа гадаад хэлний шалгалт өгнө.

3.7.5. Магистрын эрдэм шинжилгээний ажлын багц цаг нь удирдлагч багшийн удирдлага дор хичээлийн туслахаар ажиллах, бакалаврын семинарын хичээлд бэлдэх, оюутнуудын хичээлийн явцын болон улирлын шалгалтын материал засах, бакалаврын оюутнуудад хичээлийн зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээний хуралд оролцоход туслах, зөвлөгөө өгөх, удирдагч багшийн удирдлага дор судалгааны туслахаар ажиллаж судалгааны ажлын үр дүнг хөндлөнгийн хянан магадлагаа хийгдэг мөргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж цуглуулсан байх шаардлагатай.

3.7.6. Магистрын ажил нь профессор багшийн удирдлага дор магистрант бие даан эрдэм шинжилгээний судалгаа хийж, тэнхимд урьдчилсан байдлаар болон магистрын ажлыг хамгаалуулах комисст хамгаалах судалгааны ажил юм. Бүрэлдэхүүн сургуулийн онцлог, тухайн хөтөлбөрөөр олгох цогц чадамжийн шаардлагаас хамааран магистрын ажилд патент, биеэ даасан үзэсгэлэн, бизнес төлөвлөгөө, эрх зүйн бодлогын судалгааг оруулж болно.

3.7.7. Салбар дундын хөтөлбөрийн нийт багц цаг 32-36 байх бөгөөд дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Салбар дундын судлаач магистр	Салбар дундын мэргэжлийн магистр
Судалгааны арга зүй	3 багц цаг	Харилцааны чадвар эзэмшүүлэх хичээл 2 багц цаг
Мэргэжлийн хичээл	8 багц цаг	15 багц цаг
Мэргэжлийн гадаад хэл	0	0
Мэргэшүүлэх хичээл	8 багц цаг, үүнээс 3 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно	15 багц цаг, үүнээс 6 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно
Эрдэм шинжилгээний ажил	4 багц цаг	Мэргэжлийн дадлага 4 багц цаг
Магистрын ажил	9 багц цаг	
		мэргэжлийн нэгдсэн шалгалт (багц цагт орохгүй)
Нийт багц цаг	32 багц цаг	36 багц цаг

3.8. Докторын зэрэг олгох хөтөлбөрийн агуулга, шаардлага

3.8.1. Докторын зэрэг олгох хөтөлбөр нь мэргэжлийн суурь (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэжлийн заавал (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэжлийн сонгон судлах (тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, нэгжээс бусад тэнхим, салбар, бусад их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгох), удирдагч багшийн удирдлага дор хийх эрдэм шинжилгээний ажил, докторын диссертаци гэсэн бүтэцтэй байна.

3.8.2. Докторын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Докторын хөтөлбөр
Мэргэжлийн хичээл	8-9 багц цаг.
Мэргэшүүлэх хичээл	14-15 багц цаг, үүнээс 6 багц цагийг бусад тэнхим, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулиудаас сонгоно.
Эрдэм шинжилгээний ажил	12 багц цаг, удирдагч багшийн удирдлага дор 2-3 багц цагийг судалгааны сэдвийн дагуух бакалаврын хичээлийг зааж туслах багшаар ажилласан байх, багшийн судалгааны төсөлд оролцож туслах судлаачаар ажиллаж 3-аас доошгүй багц цаг цуглуулсан байх.
Диссертаци	24 багц цаг
Нийт багц цаг	60 багц цаг

3.8.3. Докторын хөтөлбөрүүдэд тухайн чиглэлээс өөр магистрын боловсрол эзэмшсэн элсэгчдэд зориулсан хөтөлбөр боловсруулж болно. Хөтөлбөрийн нийт багц цаг 15 хүртэл байх бөгөөд тухайн шинжлэх ухааны магистрын тувшийн мэргэжлийн суурь хичээлүүдээс тухайн докторантын судлах чиглэл, өмнө эзэмшсэн боловсрол, мэдлэг, туршлагыг харгалзан удирдагч багшийн саналыг үндэслэн хөтөлбөрийн дэд хороо шийдвэрлэнэ.

3.8.4. Докторант нь мэргэжлийн хичээлийн багц цагийг амжилтай судалсаны дараа докторын судалгааны ажлыг эхлүүлэхийн өмнө нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалт авах бүрэлдэхүүн, хуваарийг холбогдох тэнхим, хөтөлбөрийн хорооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирал батална.

3.8.5. Докторын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг удирдагч багшийн удирдлага дор докторант сургалтын туслах ажилтнаар ажиллаж бакалаврын хичээлийн лекц, семинарын хичээл заах, удирдагч багшийн удирдлага дор судалгааны туслахаар ажиллах, удирдагч багштай хамтарч хийсэн судалгааны ажлын үр дунг Томсон Ройтерс, Скопус зэрэг дэлхийн шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй болон бусад хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж цуглуулсан байх шаардлагатай.

3.8.6. Бүрэлдэхүүн сургуулийн онцлогоос хамааран, тухайлбал Хэрэглээний шинжлэх ухааны инженерчлэлийн сургууль, Бизнесийн сургуулийн докторантын эрдэм шинжилгээний ажлын багц цагийн тодорхой хэсгийг хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн шинжлэх ухааны парк, инкубатор төв, гарааны компани байгуулсан, өндөр технологи үйлдвэрлэлд нэвтрүүлсэн, олон улсын патент авсан бол эрдэм шинжилгээний ажилд дүйцүүлэн тооцох боломжтой.

3.8.7. Докторын диссертацийн судалгаа нь профессор багшийн удирдлага дор докторант шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэг, практик хэрэглээг хөгжүүлэх зорилтыг бие даан шийдсэн эсвэл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны онол, арга, зүйн зохих түвшинд нотолсон, шийдсэн эрдэм шинжилгээний судалгаа хийж, тэнхим/бүрэлдэхүүн сургуулийн их семинар болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаалах судалгааны ажил юм.

3.8.8. Магистр, докторын эрдэм шинжилгээний багц цаг, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг тухайн сургалтын хөтөлбөрийн дагуу тооцно.

Дөрөв. Сургалтын үйл ажиллагаа

4.1. Сургалтын зохион байгуулалтын нийтлэг шаардлага

4.1.1. Хичээлийн жилийн эхэнд МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг сургалтын нэгдсэн алба боловсруулж сургалт эрхэлсэн дэд захирал батална. МУИС-ийн сургалтын календарчилсан төлөвлөгөөг үндэслэн

бүрэлдэхүүн сургуулийн сургалтын үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг сургалтын алба боловсруулж бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулж хэрэгжүүлнэ.

4.1.2. Хичээлийн жил нь намар, хавар гэсэн үндсэн хоёр улиралтай зуны буюу нэмэлт улиралтай байна. Намар, хаврын улирал эхлэхээс өмнөх 7 хоногт тухайн улиралд суралцагч судлах хичээлийн агуулгатай танилцаж, хичээлд бүртгүүлэн баталгаажуулалт хийх “тэг” долоо хоногтой байна. “Тэг” долоо хоног нь танхимын сургалтын долоо хоногт орохгүй.

4.1.3. Зуны улирал нь суралцагчийн саналыг үндэслэн, сургалтын албаны шийдвэрээр дадлагатай, нөхөн сургалт, 4.1.5-ын хувилбар 5-аар орох хичээлүүд байх бөгөөд хичээл, шалгалтыг оролцуулан 8 долоо хоногоос хэтрэхгүй байна.

4.1.4. Хичээлийн улирал бакалаврын хөтөлбөрийн хувьд танхимын сургалтын хугацаа 16 (лекц, семинар, мэдлэг ур чадвараа үнэлүүлэх, явцын шалгалтыг агуулна) шалгалтын 2, нэгтгэн дүгнэх 1, нийт 19 долоо хоног, магистр, докторын хөтөлбөрийн хувьд танхимын 10, судалгааны 4, шалгалтын 1 нийт 15 долоо хоногтой байна.

4.1.5. Хичээлийн төрөл хэлбэрээс шалтгаалж нэг багц цагийг өөр өөрөөр тооцох бөгөөд дараах хувилбаруудын аль нэгийг харгалзах төрлийн хичээлд тэнхмийн, тэнхимгүй бүтцийн хувьд сургуулийн хөтөлбөрийн дэд хороо боловсруулан батална.

Хувилбар	Хичээлийн 7 хоногт зааж болох хэлбэр	Тайлбар
1	Зөвхөн лекц	Нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн онолын мэдлэг олгоход чиглэсэн хичээлүүдийг энэ хувилбараар орох нь зохимжтой /Ерөнхий суурь/.
2	Лекц, семинар эсвэл лаборатори хосолсон /багц цагийн харьцаа 2:1/	Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн онолын мэдлэг, туршилт, практик дээр үндэслэн ур чадвар, дадал, олгоход чиглэсэн хичээлүүдийг энэ хувилбараар орох нь зохимжтой /Ерөнхий суурь/, Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл/.
3	Лекц, семинар эсвэл лаборатори хосолсон /багц цагийн харьцаа 1:2/	Байгалийн ухааны чиглэлийн, туршилт, практик, судалгаан дээр үндэслэн ур чадвар, дадал олгоход чиглэсэн хичээлүүдийг энэ хувилбараар орох нь зохимжтой. /Ерөнхий суурийн гадаад хэлний хичээл , Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл /
4	Зөвхөн семинар эсвэл лаборатори	Гадаад, дотоодын зочин багшийн хичээлүүдийг энэ хувилбараар орох нь зохимжтой. / Богино хугацаанд заах хичээл /
5	Танхимд 48 цагаас доошгүй заах лекц, семинар, лабораторийн хичээл	

4.1.6. Бакалаврын оюутны суралцаж буй түвшинг амжилттай судалсан буюу цуглуулсан багц цагаар тогтооно. Сургалтын төлбөрийг тооцох үед оюутны түвшинг тодорхойлохдоо цуглуулсан багц цаг, судлахаар сонгосон багц цагаар тодорхойлно.

Суралцах хэлбэр	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин	5-р түвшин /ХЗС/
Өдөр	0-30	31-60	61-90	91 ба түүнээс дээш ХЗС-ийн хувьд 91-120	121 ба түүнээс дээш
Орой, эчнээ		0-30	31-60	61-90	-91 ба түүнээс дээш <i>ИХД0072 9104399</i>

4.1.7. МУИС-ийн бакалаврын түвшний хөтөлбөрийн хичээлд мэргэжлийн шаардлага хангасан иргэд сургалтын албанда хүсэлт гаргаж, журмын 4.13.14-т заасны дагуу улирлын суурь үйлчилгээний төлбөр төлсний үндсэн дээр 15 багц цаг хүртэлх хичээлийг сонгон судалж болно. Иргэн хүсвэл МУИС-ийн оюутантай адил дүгнүүлж дүнгийн тодорхойлолт авч болно.

4.2. Элсэлтийн үйл ажиллагаа

4.2.1. МУИС-д бакалавр, магистр, докторын хөтөлбөрт оюутан элсүүлэх үйл ажиллагааг жил бүрийн элсэлтийн журмаар зохицуулна.

4.2.2. МУИС-д суралцагч элсүүлэх шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулна.

4.2.3. Гадаадын иргэнийг МУИС-д элсүүлэх, оюутан солилцооны болон зуны хөтөлбөрт суралцуулах асуудлыг тусгай журмаар зохицуулна.

4.2.4. Суралцагч дотоод, гадаадын их дээд сургуулиас болон тус их сургуулийн аль нэг үндсэн мэргэжлийн хөтөлбөрөөс нөгөөд шилжин суралцаж болно. Энэ асуудлыг “Суралцагч шилжүүлэн суралцуулах” журмаар зохицуулна.

4.2.5. Бакалаврын элсэлт

4.2.5.1. Бакалаврын өдөр, орой, эчнээ хөтөлбөрийн элсэлтийг жилд 1 удаа зохион байгуулна.

4.2.5.2. Бүрэн дунд боловсролтой, элсэлтийн ерөнхий шалгалтыг зохих журмын дагуу амжилттай өгч, элсэх эрх авч баталгаажуулсан элсэгчийг МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт өдрөөр суралцуулна.

4.2.5.3. Бакалаврын зэрэгтэй, элсэлтийн шалгалтыг амжилттай өгч, элсэх эрх авч баталгаажуулсан элсэгчийг МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт орой, эчнээ хэлбэрээр суралцуулахаар элсүүлнэ.

4.2.5.4. Бакалаврын зэрэгтэй иргэн өөр мэргэжлээр өдрийн хөтөлбөрт суралцах хүсэлтэй бол элсэлтийн ерөнхий шалгалт өгч, элсэнэ. Элссэний дараа өмнө нь бакалаврын зэрэг эзэмшихдээ судалсан хичээлээс 45 хүртэл багц цагийг дүйцүүлэн тооцуулж болох ба үүнийг сургалтын алба хариуцан зохион байгуулна.

4.2.6. Магистр, докторын элсэлт

4.2.6.1. Магистр, докторын хөтөлбөрийн элсэлтийг жилд 1-2 удаа зохион байгуулна.

4.2.6.2. Тухайн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, элсэлтийн шалгалтыг амжилттай өгч, бусад шаардлагыг биелүүлж элсэх эрх авсан элсэгчийг МУИС-ийн магистрын хөтөлбөрт суралцуулна.

4.2.6.3. Тухайн мэргэжлээр магистрын хөтөлбөрийг амжилттай дүүргэж магистрын зэрэг авсан, элсэлтийн шалгалтыг амжилттай өгч, бусад шаардлагыг биелүүлж элсэх эрх авсан элсэгчийг МУИС-ийн докторын хөтөлбөрт суралцуулна.

4.2.6.4. Өмнө эзэмшсэн бакалавр, магистрын мэргэжил нь өөр чиглэл (эрх зүйн хөтөлбөрөөс бусад)-тэй элсэлтийн шалгалтанд тэнцсэн иргэдийг нөхцөлтэй элсүүлэх бөгөөд журмын 3.7.2, 3.8.3-д заасан хөтөлбөрийг амжилттай дүүргэсний дараа үндсэн магистр, докторын хөтөлбөрт суралцуулна.

4.2.6.5. Магистр, докторын хөтөлбөрт бүртгүүлэгчийн тоо цөөн, анги бүрдэх боломжгүй тохиолдолд тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх эсэхийг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо шийднэ.

4.2.6.6. Дараах болзول хангасан докторантыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэрээр экстернат хэлбэрт шилжүүлэх бөгөөд бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна. Үүнд:

- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад сургалт, эрдэм шинжилгээний ажлыг 8-аас дээш жил хийсэн туршилагатай,
- Эрдэм шинжилгээ, сургалтын 15-аас доошгүй бүтээл хэвлэн нийтлүүлсэн, үр дүн нь диссертацид орохгүй бүтээлүүд нь мэргэжлийн ба мэргэшүүлэх хичээлүүдийн багц цагтай дүйцүүлэн тооцох боломжтой,
- Агуулга нь докторын диссертацийн 75 дээш хувийг хангахуйц бүтээл бичиж бэлэн болгосон.

4.2.6.7. Экстернатаар суралцахыг хүссэн докторантын эрдэм шинжилгээний ажлын агуулга, чанар, үр дүнгийн талаар үнэлгээ өгч, бүтээлээр нь тооцох багц цагийг тодорхойлж, суралцах болзол хангасан тухай бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэр гарсан байна.

4.3. Бакалаврын сургалтын онцлог

4.3.1. Үндсэн, хавсарга болон хос мэргэжлийн хөтөлбөр сонгох

4.3.1.1. Үндсэн мэргэжлийн хөтөлбөр сонголтыг жил бүрийн 1 болон 6-р сард МУИС-ийн захирлын тушаалаар томилогдсон төв болон салбар комисс зохион байгуулах бөгөөд тусдаа журмаар зохицуулна.

4.3.1.2. Журмын 3.6.13-д заасан шаардлагыг хангасан бакалаврын өдрийн хөтөлбөрийн оюутан хавсарга болон хос мэргэжлээр суралцах хүсэлтийг тухайн хичээлийн жилийн 10 болон 3-р сард багтаан өгнө.

4.3.1.3. Сургалтын алба хавсарга болон хос мэргэжлээр суралцах хүсэлтийг тухайн хичээлийн жилийн 11 болон 4-р сарын эхний 2 долоо хоногт багтаан харгалзах тэнхмийн саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

4.3.1.4. Хавсарга мэргэжлээр суралцуулах шийдвэр гарсны дараа сургалтын албанаас тухайн оюутанд сургалтын мэдээллийн системд хичээл сонгох эрхийг нээнэ.

4.3.1.5. Хос мэргэжлээр суралцах эрхийг бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна. Тушаалыг үндэслэн сургалтын албанаас тухайн оюутанд сургалтын мэдээллийн системд хичээл сонгох эрхийг нээнэ.

4.3.1.6. Хавсарга болон хос мэргэжлээр суралцуулах тушаал гарсны дараах улирлаас эхлэн суралцуулна.

4.4. Магистр, докторын зэрэг олгох сургалт

4.4.1. Магистрант, докторант нь элссэн эхний улиралд багтаан төгсөлтийн дараах сургуулийн баталсан ганцаарчилсан төлөвлөгөөний үлгэрчилсэн загварын дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулж, тэнхмийн эрхлэгч/хөтөлбөрийн удирдагч, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны эрхлэгчээр баталгаажуулна.

4.4.2. Магистрант, докторантын элссэн улиралд багтаан мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн удирдагч, суралцагчийн саналд тулгуурлан бүрэлдэхүүн сургууль суралцагч нэг бүрээр удирдагч багшийг томилох саналыг боловсруулж бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

4.4.3. Магистрант, докторантын удирдагч, хичээл заах багш докторын зэрэгтэй байна.

4.4.4. Удирдагч багш нь магистрант, докторантын судалгааны ажлын сэдэв, судалгааны ажлын төлөвлөгөөг чиглүүлэн тогтоож, биелэлтийг нь хянаж, туршилт хийх, задлан шинжлэх, туршилтын дүнг боловсруулах, өгүүлэл бичих, илтгэл тавих зэргийг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Удирдагч багш магистрын ажил, докторын диссертаци

УХД0072 9104399

бичихэд зөвлөн, түүний агуулга, чанар, судалгааны ажлын үр дүнгийн шинжлэх ухааны үнэн зөв байдал, хууль эрхийн хүрээнд хийгдсэн эсэхийг хянах, удирдагчийн хувиар хариуцлага хүлээнэ.

4.4.5. Магистрант, докторант нь магистрын ажил, докторын диссертацийн сэдэв, сэдвийн дагуу судалгаа хийх төлөвлөгөөг удирдагчтай зөвшилцэн боловсруулна.

4.4.6. Магистрант, докторант нь удирдагч багшaa ~~оөрчлөх~~ хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн удирдагч, удирдагч ~~профессорын~~ саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

4.4.7. Экстернат хэлбэрээр суралцах докторантын мэргэших хичээлийн 18 хүртлэх багц цагийг бүтээлүүдээр нь дүйцүүлэн тооцож болно. Дүйцүүлэн тооцож болох цагийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын томилсон комисс үнэлж, бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр батлуулна. Тухайн хичээлийг сургалтын мэдээллийн системд удирдагч багш дээр оноож үсгэн үнэлгээ (CR)-г оруулна. Дүйцүүлэн тооцож болох бүтээлд:

- a) Үр дүн нь диссертацийн ажилд орохгүй, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл,
- c) Их сургуулийн сурх бичиг,
- d) Хэвлүүлсэн монографи,
- e) Зохион бүтээсэн багаж төхөөрөмж, тогтоосон стандарт, патент,
- f) Байгуулсан эрдэм шинжилгээний лаборатори, эрдэм шинжилгээний музей,
- g) Зарим боловсруулалтууд (компьютерийн програм, газрын зураг/карт, хуулийн төсөл, бизнесийн кейс судалгаа албан ёсоор улсын хэмжээнд мөрдөж буй аргачлал, стандарт гэх мэт).

4.4.8. МУИС-ийн бакалаврын 3-р түвшинг 3.2-оос дээш голчтой дүүргэсэн мэргэжлийн чиглэлээр магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй оюутан холбогдох тэнхим, сургалтын албаны зөвшөөрлөөр магистрын судалгааны арга зүй, мэргэжлийн хичэлүүдээс сонгон судлах боломжтой. Бакалаврын зэрэг авсны дараа тухайн магистрын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид бакалавр, магистрын зэргэцсэн (integrated) хөтөлбөр гэнэ.

4.4.9. МУИС-ийн судалгааны магистрын 15-аас дээш багц цагийн хичээлийг амжилттай 3.0-аас дээш голчтой дүүргэсэн тухайн мэргэжил, судалгааны чиглэлээр докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй магистрант холбогдох тэнхим, сургалтын албаны зөвшөөрлөөр докторын хичэлүүдээс сонгон судлах боломжтой. Магистрын зэрэг авсны дараа тухайн докторын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид магистр, докторын зэргэцсэн хөтөлбөр гэнэ.

4.4.10. Журмын 4.4.8, 4.4.9, 4.6.13-д тооцсон хичээлийг тухайн хичээлийн шилжиж ирсэн улиралд оноож дүнг үндсэн үнэлгээгээр сургалтын алба оруулна.

4.4.11. Суралцагчийн судалгааны чиглэлээр зайлшгүй судлах шаардлагатай мэргэшүүлэх хичээл МУИС дээр заагддаггүй бол удирдагч багшийн зөвшөөрлөөр МУИС-тай гэрээтэй магадлан итгэмжлэгдсэн их сургууль, үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хүрээлэн, төвд б хүртэлх багц цагийг судалж болно. Ийм хэлбэрээр судалсан хичээлийн дунг тухайн байгууллагаас албан ёсоор ирүүлсэн багц цаг, дүнгийн тодорхойлолтыг үндэслэн тооцно. Тухайн хичээлийг сургалтын мэдээллийн системд удирдагч багш дээр оноож зохих үнэлгээг оруулж, багц цагийн төлбөрийг сургалтын мэдээллийн системээр хийнэ. Бусад холбогдох асуудлыг гэрээний дагуу шийдвэрлэнэ.

4.5. Хичээл, хичээлд бүртгүүлэх

4.5.1. МУИС-д заагдах нэг хичээлийн агуулга нэг улиралд багтаан заагдах боломжтой байна. Агуулгын багтаамж ихтэйгээс хоёр, түүнээс дээш улирал дараалан, эсвэл дараалсан бус улиралд заагдахаар хөтөлбөрийн дэд хорооноос баталсан тохиолдолд хичээлийг агуулгын залгамж холбоо бүхий тусдаа хичэлүүдэд хувааж, тус бүрд нь нэр, индекс, багц цаг онооно.

4.5.2. Багш лекцийн тэмдэглэл, семинарын бодлого, асуулт, гэрийн даалгавар, бие даалтын материал зэрэг зааж буй хичээлийн хэрэглэгдэхүүнээ МУИС-ийн нээлттэй сургалтын цахим хуудсанд байршуулан, хүртээмжийг нь нэмэгдүүлнэ. Эд цахим хуудсанд байршсан бүх хичээлийн хэрэглэгдэхүүн МУИС-ийн оюуны өмч болно.

4.5.3. Хөтөлбөрийн зөвлөх багшийг хичээлийн жил бүр бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар томилно. Хөтөлбөрийн зөвлөх багш тухайн хичээлийн жилд элссэн 25-30 оюутантай бүлэгт сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой зөвлөгөө өгнө.

4.5.4. Хичээлийн хөтөлбөрийн стандарт, хувилбарыг багш бүр мөрдөхийн зэрэгцээ мэдлэг, туршилагадаа тулгуурлан, судалж буй оюутнуудын мэргэжлийн онцлог, эрэлтэд нийцүүлж баяжуулан заана.

4.5.5. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороод батлагдсан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болох сургалтын төлөвлөгөө, дараагийн улиралд заах хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийг тухайн улирлын 11 дэх долоо хоногийн дотор сургалтын албанад өгч сургалтын мэдээллийн системд байршуулна. Мэдээлэл бүрэн бус хичээлийг дараагийн улирлын хичээлийн тандалт, хуваарьт оруулахгүй.

4.5.6. Нэг хичээлийг хэд хэдэн багш хамтран зааж болно. Хамтран заах тохиолдолд өмнөх улиралд багтаан тэнхмийн эрхлэгч/хөтөлбөр хариуцсан дэд захиралд мэдэгдэнэ.

4.5.7. Багш тухайн улирлын 11 дэх долоо хоногт дараагийн улиралд заах хичээлийн хүсэлтээ тэнхим, сургалтын албанад өгч баталгаажуулсан байна. Нэг хичээлийг хоёроос дээш багш заах сонголттойгоор төлөвлөж, суралцагчид багшийг сонгох боломж олгох бөгөөд анги бүрдээгүй тохиолдолд илүү санал авсан багшаар тухайн хичээлийг оруулна.

4.5.8. Хичээлд бүртгүүлэх үйл ажиллагаа нь хичээлд санал өгөх, баталгаажуулалт гэсэн хоёр үе шаттай, цахим хэлбэрээр явагдана.

4.5.9. Бакалаврын хөтөлбөрийн хувьд оюутан улиралд дунжаар 15 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн доод хэмжээ 12, дээд хэмжээ 21 байна.

4.5.10. Магистрын хөтөлбөрийн хувьд улиралд дундааар 10 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 12 (ХЗС бол 13) байна. Докторын хөтөлбөрийн хувьд улиралд дундааар 10 (энээ бол 6) багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 15 (ХЗС бол 13) байна.

4.5.11. Суралцагч судалж буй хичээлийн агуулга, чанар, багшийн заах арга, ёс зүй, харилцаа, суралцах орчны талаарх судалгааг цахим хэлбэрээр өгснөөр дараа улирлын хичээлийн санал өгөх эрх нээгдэнэ.

4.5.12. Суралцагч тухайн улирлын 13, 14 дэх долоо хоногт багтаан дараагийн улиралд судлах хичээлд санал өгнө. Санал өгснөөр хичээл баталгаажуулалтын хугацааны 50 хувьд тухайн хичээлийг баталгаажуулах давуу эрх эдэлнэ.

4.5.13. Мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн дэд хороо хичээлийн саналыг үндэслэж 15, 16 дахь долоо хоногт багтаан хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж, сургалтын мэдээллийн системд байршуулан, сургалтын албанад баталгаажуулж өгнө.

4.5.14. Мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн дэд хорооны саналыг үндэслэн сургалтын алба дараагийн улиралд орох хичээл, заах багшийн нэр, анги танхим, цаг бүхий хичээлийн хуваарийг улирлын шалгалтын хугацаанд бэлэн болгоно. Хичээлийн хуваарийг сургалтын албаны эрхлэгч батална.

4.5.15. Суралцагч хичээлийн хуваарийг үндэслэн тухайн улирал эхлэхээс өмнөх долоо хоногт хичээлийг сонгон бүртгүүлэх ба бүртгүүлсэн хичээлийн багц цагийн төлбөр, тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг цахим хэлбэрээр төлж, баталгаажуулна.

4.5.16. Магистр, докторын эрдэм шинжилгээний ажил, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг төгсөх улиралдаа сургалтын мэдээллийн системээр сонгон баталгаажуулна.

4.5.17. Хичээлийг сонгон бүртгүүлснээс хойш 24 цагийн дотор төлбөрөө төлөн баталгаажуулна. Баталгаажуулаагүй хичээлийг цуцална. Хэрэв тухайн хичээлийг судлах оюутны тоонд багтахгүй бол хүлээлгийн жагсаалтанд нэрээ бүртгүүлж болно.

4.5.18. Суралцагч баталгаажуулсан хичээлийг хичээлд бүртгүүлэн, баталгаажуулах хугацаанд өөрөө цуцалж болно.

4.5.19. Анги бүрдэлт бакалаврын хөтөлбөрийн хувьд ~~ерөнхий суурин~~ англи хэлний 30, бусад гадаад хэлний хичээл 15, биений тамирын хичээл ~~40~~, ~~ерөнхий суурин~~ лекцийн хичээл 50, ерөнхий суурь семинар, лабораторийн хичээл 25, мэргэжлийн суурь лекцийн хичээл 25, мэргэжлийн семинар, лабораторийн хичээл 15-аас багагүй, магистрын хөтөлбөрийн хувьд 5, докторын хөтөлбөрийн хувьд 3-аас доошигүй суралцагчтай байх нь зохимжтой.

4.5.20. Анги бүрдээгүй тохиолдолд сонгон суралцах хичээл бол өөр ижил төстэй хичээлийг санал болгох, мэргэжлийн заавал үзэх хичээл бол тэнхим, сургалтын албаны саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөл шийднэ.

4.5.21. Улирлын эхний долоо хоногт багтаан анги бүрдээгүйгээс суралцагчийн баталгаажуулсан хичээлийг цуцлах асуудлыг сургалтын алба шийднэ. Тухайн цуцалсан хичээлийг баталгаажуулсан багц цагийн төлбөрийг суралцагчийн дансанд буцаан байршуулж өөр хичээл сонгох эсвэл дараа улирлын төлбөрт шилжүүлэх боломжийг олгоно. Төгсөх ангийн суралцагч бөгөөд санхүүгийн тооцоогүй бол тойрох хуудас зурагдсаны дараа төлбөрийг буцаан олгоно.

4.5.22. Хүндэтгэн үзэх шалтгаанаар заасан хугацаанд хичээлдээ бүртгүүлж амжаагүй суралцагч тухайн улирлын эхний 7 хоногт багтан бүртгүүлэх боломжтой хичээлд бүртгэлийн хураамж төлж бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь суралцаж буй түвшний 1 багц цагийн төлбөртэй дүйцэхүйц байна.

4.5.23. Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн 70 хувийг дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Хичээлийн цагийн 30-аас дээш хувь өнгөрсөн бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй. Аль ч тохиолдолд тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг буцааж олгохгүй.

4.5.24. Хичээлд бүртгүүлээгүй суралцагчийг хичээлд суулгаж дүгнэхийг хориглоно.

4.5.25. Эчнээ хэлбэрээр суралцагч тухайн улирлын хичээл эхлэх өдрөөс өмнөх долоо хоногт хичээлд бүртгүүлж, баталгаажуулна.

4.5.26. Багш тухайн улиралд зааж буй хичээл тус бүрээр хуваарийн дагуу суралцагчид зөвлөгөө өгнө. Зөвлөгөө өгөхөд хичээл тус бүрээр долоо хоногт 90 минутыг зориулна.

4.6. Суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээ

4.6.1. Хичээлээр эзэмшсэн суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг хөхиүүлэн дэмжих, хөгжүүлэх, оюутны суралцах, багшийн сургах хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгох бөгөөд үнэлгээ шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байна.


4.6.2. Ижил мэргэжлээр суралцаж байгаа өдөр, орой, эчнээ хөтөлбөрийн суралцагчийн мэдлэг, чадварыг сургалтын нэгэн ижил хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн агуулгаар дүгнэж, үнэлнэ.

4.6.3. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь шалгалт байна.

4.6.4. Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно. Голч оноо, голч дүнг бодохдоо багц цаг бүхий хичээл бүрээр оюутны авсан оноо/дүнг харгалзах багц цагаар нь үржүүлж,

тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хувааж (арифметикийн жинлэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.

$$GO = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot O_i}{\sum_{i=1}^n K_i} \quad GD = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot D_i}{\sum_{i=1}^n K_i}$$



n - хичээлийн тоо

K_i - тухайн (i) дугаар хичээлийн багц цаг

O_i (D_i) - тухайн (i) дугаар хичээлийн оноо (дүн)

GO (GD) - голч оноо (голч дүн)

4.6.5. Суралцагч улирал бүр тухайн улирлын мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнтэйгээ танилцан, сурлагынхаа байдалд үнэлэлт дүгнэлт хийж цаашид суралцах үйл ажиллагаагаа төлөвлөнө.

4.6.6. Суралцагчийн голч оноо, голч дүнг улирал, хичээлийн жил, суралцсан хугацаа, мэргэжлийн хөтөлбөр, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд суралцагчийг байр эзлүүлэхэд ашиглах буюу оюутныг үндсэн мэргэжлийн хөтөлбөр сонгуулах, хавсарга болон хос мэргэжил эзэмшүүлэх, бакалавр, магистрын зэргэцсэн хөтөлбөрт суралцуулах, суралцагчийг шагнах, тэтгэлэг олгохоор тодорхойлох, магистр, докторын зэргэцсэн хөтөлбөрт суралцуулах, төгсгөх, оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, магистр, докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн сургах зэрэгт гол үзүүлэлт болгоно.

4.6.7. Суралцагч шалгалт өгөхдөө заавал суралцагчийн үнэмлэхтэй ирнэ.

4.6.8. Журмын 4.9-ын дагуу хөндлөнгийн шалгалт авч болно.

4.6.9. Семинар, лабораторийн хичээл, судалгааны ажил бусад бие даалтын ажлаар олсон мэдлэг, чадварыг үнэлэхэд төсөл, тайлан хамгаалалт, явцын шалгалт, тест, ангийн ажил болон тэдгээртэй дүйцэх бусад хэлбэрийг ашиглана.

4.6.10. Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлээр хийх дадлагад багц цаг харгалзуулсан бол тэдгээрийн тайлангийн хамгаалалтыг шалгалтын нэгэн адил үзэж оноогоор үнэлнэ. Дадлагын тайланг холбогдох салбар, мэргэжлийн тэнхмийн дадлагын удирдамжийн дагуу хамгаалуулах ба оюутны дадлагын хичээлийг тусад нь журмаар зохицуулна.

4.6.11. Ерөнхий суурь хичээлийн үнэлгээ

4.6.11.1. Ерөнхий суурь хичээлийн шалгалтыг тест болон бусад хэлбэрээр авна.

4.6.11.2. Ерөнхий суурь хичээлийн явцын шалгалтыг ямар хэлбэрээр авахыг хичээл зааж буй багш шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд мэдэгдэнэ.

4.6.11.3. Ерөнхий суурь хичээлийн тестийн сан тухайн бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанад бүрдсэн байх ёстой.

4.6.11.4. Явцын болон улирлын тест (сорилго) хэлбэрийн шалгалтыг сургалтын алба зохион байгуулж оюутнуудын дүнгийн мэдээллийг хичээл зааж буй багшид ажлын 2 хоногийн дотор өгнө.

4.6.11.5. Ерөнхий суурь хичээлийн явцад хөтөлбөрийн дэд хорооны гишүүд түүвэр байдлаар хичээлд сууж хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, захиргааны зөвлөлд тайлagnana.

4.6.11.6. Ерөнхий суурь хичээлийн явцад оюутны бие даалтын үйл ажиллагааг удирдан зөвлөгөө өгөх тогтмол цаг тогтоох бөгөөд хуваарийн дагуу багш, хичээлийн туслах нар оюутантай ажиллаж зөвлөгөө өгөх ажлыг улирлын турш зохион байгуулна.

4.6.11.7. Ерөнхий суурийн англи хэлний хичээлийн агуулгын шаардлагыг хангасан мэдлэгтэй суралцагч нь тухайн чиглэлээр гадаад хэлний төвд шалгалт өгч эсвэл TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний онооноос дээш оноотой бол дүйцүүлэн тооцуулж болно. Дүйцүүлэн тооцсон хичээлийг сургалтын мэдээллийн системд тэмдэглэхдээ тухайн

хичээлийн жилийн шилжиж ирсэн улиралд оноож дүнг үндсэн гүнэлгээгээр бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба оруулна.

4.6.11.8. МУИС-ийн харьяа байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай “Байгаль-Эх” лицей ахлах сургууль болон МУИС-тай багц цаг тооцох гэрээ байгуулсан ахлах сургуулийг төгссөн сургач ерөнхий суурь хичээлийн байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны багцаас гүнзгийрүүлэн судалсан 85-аас дээш үнэлгээтэй хичээлийг дүйцүүлэн тооцуулж болно. Дүйцүүлэн тооцсон хичээлийг сургалтын мэдээллийн системд тэмдэглэхдээ тухайн хичээлийн жилийн шилжиж ирсэн улиралд оноож дүнг үндсэн гүнэлгээгээр бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба оруулна.

4.6.12. Суралцагчийн тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээ

4.6.12.1. Тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээ гаргахдаа оюутны хичээлийн явцын идэвх оролцоо, бие даасан ажиллагааны завсрлын хяналтын үнэлгээ, улирлын шалгалтын үнэлгээ тус бүрийг зохих хэмжээгээр тооцон “суралцагчийн мэдлэг, чадварыг оноогоор үнэлэх аргачлал” (Хавсралт 1)-ын дагуу 100 оноогоор үнэлнэ.

4.6.12.2. Хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан суралцагчийг уг хичээлийн агуулгыг судалж, багц цагийг биелүүлсэн гэж үзнэ. Харин 60-аас бага оноо авсан суралцагчийг “хангалтгүй” суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ.

4.6.12.3. Багц цаг тооцохгүй хичээлийн шалгалтыг авахдаа шалгалтын адил 100 оноогоор үнэлнэ. Суралцагчийн авсан оноо нь 60 ба түүнээс дээш бол “тооцов”, 60-аас доош бол “үл тооцов” гэж дүгнэх бөгөөд үнэлгээг харгалzan “S”, “U” гэж бичнэ.

4.6.12.4. Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хэлбэртэй байна. Үүнд:

Хувьчилсан оноо	Үсгээр илтгэсэн дүн	Тоогоор илтгэсэн дүн
95-100	A	4.0
90-94	A-	3.6
85-89	B	3.1
80-84	B-	2.7
75-79	C	2.3
70-74	C-	1.9
65-69	D	1.4
60-64	D-	1.0
0-59	F	0

4.6.12.5. Суралцагчийг үнэлэхдээ тоо болон үсгээр илтгэсэн дүнг хэрэглэхээс гадна I, E, NC, CR, R, W, NA, NR, S, U гэсэн нэмэлт тэмдэглэгээг хэрэглэнэ. Эдгээр тэмдэглэгээ нь суралцагчийн голч дүн буурах шалтгааныг тогтоох, суралцагч голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох, бусад сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох зэрэгт хэрэглэгдэнэ. Нэмэлт тэмдэглэгээг дор үзүүлэв.

I	(Incomplete)
	Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ (реферат, даалгавар, дадлагын ажил дутуу, явцын шалгалтанд орж чадаагүй гэх мэт) дутуу боловч шалгалтын хугацаанд нөхөн гүйцэтгэж, шалгуулах нөхцөлтэйгээр хэрэглэнэ.

E	(Examine incomplete by student)
	Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтанд ороогүй бол багш (эсвэл сургалтын албаны эрхлэгч) энэ тэмдэглэгээг бичнэ.
NC	(No Credit)
	Багц цаг тооцохгүй бөгөөд уг хичээлийг суралцагч судалсан, гэсэн тэмдэглэгээ. Кредит тооцуулахгүйгээр хичээл судлах зөвшөөрөл авч амжилттай судалсан тохиолдолд тавигдах тэмдэглэгээ юм.
CR	(Credit gRanted)
	Өөр сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох үед энэ тэмдэглэгээг хийх ба дипломын хавсралтан дээр энэ хэвээрээ бичигдэнэ.
R	(Repeat)
	Тухайн хичээлийг амжилттай судалсан ч тодорхой шаардлагаар дахин судлах хүсэлт гаргасан бол суралцагчийн өмнөх үнэлгээний үсгээр илтгэсэн дүнг R болгож, дахин судлах боломжоор хангана.
W	(Withdrew)
	Хэрэв суралцагч хичээлийг цаашид судлах боломжгүй эсвэл хангалтгүй судалсан бол улирлын шалгалтаас 7 хоногийн өмнө өөрийн саналаар уг тэмдэглэгээг багшид хүсэлт гаргаж хийлгэнэ. Суралцагч чөлөө авсан, хасагдсан, гарсан тохиолдолд дүгнэгдээгүй хичээлийн дүнг системээс тавина. Дараа нь тус хичээлийг шинээр үзэх хичээлийн адил бүртгүүлж судална.
NA	(grade Not yet Available)
	Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ.
NR	(No grade Reported)
	Багш эцсийн үнэлгээгээ үнэлгээ тавих хугацааны дотор тавьж, системд оруулаагүй тохиолдолд мэдээллийн системээс автоматаар тавьсан тэмдэглэгээ.
S	(Satisfactory)
	“Тооцов” тэмдэглэгээ.
U	(Unsatisfactory)
	“Үл тооцов” тэмдэглэгээ.

4.6.12.6. Шалгагч багш дүнгээ шалгالت авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор сургалтын мэдээллийн системд оруулах үүрэгтэй. Шалгагдвал зохих суралцагчийн нэрс, өөрийн тавьсан дүн бүхий хуудсыг (хавсралт 2) хэвлэн, хянан, гарын үсгээр баталгаажуулан сургалтын албанд хүлээлгэн өгнө. Сургалтын албаны бүртгэл хариуцсан мэргэжилтэн хүлээн авч баталгаажуулна. Гараар заасвар хийсэн шалгалтын хуудас хүчингүй.

4.6.12.7. Хичээлийн дүнг сургалтын мэдээллийн системд заасан хугацаанд оруулаагүй бол багшид хариуцлага тооцох үндэслэл болно.

4.6.12.8. Хүндэтгэх шалтгаангүйгээр улирлын шалгалтанд ирээгүй суралцагчид “F” буюу “хангалтгүй” үнэлгээ тавина. Харин хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол нотлох бичиг баримтыг үндэслэн “E” тэмдэглэгээг хийнэ. Нотлох баримтыг өргөдлийн хамт шалгальт авснаас хойш 3 хоногийн дотор багшид өгнө. Багш нотлох баримт, өргөдлийг дүнгийн жагсаалтын хамт сургалтын албанд өгнө. I, E тэмдэглэгээтэй суралцагч дараагийн улирлын эхний 1 сард багтаан шалгуулахгүй бол сургалтын албанаас F дүн тавина.

4.6.12.9. Нэмэлт тэмдэглэгээ тавигдсан хичээлийн багц цагийг улирлын болон нийт голч оноо, голч дүнг бодоход хэрэглэхгүй.

4.6.12.10. Явцын үнэлгээ нь идэвх, оролцооны үнэлгээ (О1) болон явцын үнэлгээ (О2) гэсэн хоёр хэсгээс тогтох ба хэсэг бүрийг “Суралцагчийн мэдлэг, чадварыг оногоор үнэлэх аргачлал” (хавсралт 1)-ыг баримтлан үнэлнэ.

4.6.13. Магистрын хөтөлбөрийн хувьд мэргэжлийн гадаад хэлний хичээлийн агуулгын шаардлагыг хангасан мэдлэгтэй суралцагч нь тухайн чиглэлээр шалгалт өгч дүйцүүлэн тооцуулж болно.

4.6.14. Магистр, докторын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг тооцох комиссыг бүрэлдэхүүн сургуулийн тэнхмийн тэнхимгүй бүтцийн хувьд хөтөлбөрийн удирдагчийн саналыг ундэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

4.6.15. Магистр, докторын эрдэм шинжилгээний ажил, магистрын ажил, докторын диссертацийн дүнг сургалтын мэдээллийн системд тэнхмийн эрхлэгчид оноож үнэлгээг оруулна.

4.7. Шалгалтын үйл ажиллагаа

4.7.1. Шалгалтын үнэлгээ нь суралцагчийн тухайн хичээлийн туршид эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг эзэмшсэн эсэхийг үнэлэн тогтоох үзүүлэлт юм.

4.7.2. Багш шалгалтын үнэлгээг хэрхэн үнэлж, дүгнэхээ хичээлийн эхэнд оюутнуудад мэдэгдсэн байна.

4.7.3. Шалгалт нь явцын, улирлын болон нэгдсэн гэсэн 3 хэсгээс бүрдэнэ.

4.7.4. Явцын болон улирлын шалгалтыг 1 удаа тус тус авна.

4.7.5. Шалгалтыг тухайн хичээл ордог хуваарьт хугацаанд авна.

4.7.6. Эчнээ хэлбэрээр суралцаж буй суралцагчийн хувьд шалгалтыг улирлын төгсгөлд, эсвэл дараагийн улирлын эхэнд хичээл сонгон баталгаажуулалт эхлэхээс өмнө зохион байгуулна. Суралцагч бие дааж гүйцэтгэх даалгаврын биелэлтийг шалгалт эхлэхээс 21 хоногийн өмнө шалгагч багшид ирүүлсэн байна.

4.7.7. Шалгалт авах хэлбэр, даалгаврын (асуултын) тоо, түүний агуулга, бүтэц, хариулт бэлтгэх хугацаа зэргийг багш сургах арга зүйн үүднээс нарийн төлөвлөж, боловсруулсан байна. Улирлын шалгалтын үйл ажиллагаанд тэнхим/салбар, сургалтын алба хяналт тавина.

4.7.8. Улирлын шалгалт авахдаа хичээлээр эзэмшүүлсэн мэдлэг, ур чадварыг шалгах даалгавар (асуулт), асуудал шийдвэрлүүлэх зэрэг бүтээлч хэлбэрийг ашиглаж болно.

4.7.9. Шалгалт авч байх үед баримтлах дэг журмыг (оюутны тухай мэдээллийн чанартай заавал бичих зүйлийг дурьдсан байх /нэр, бүртгэлийн дугаар, сургууль, түвшин, даалгаврын хувилбар гэх мэт/, хэдий хугацаа шаардагдах, хариултыг хэрхэн тэмдэглэх, дасгал бурийн дээд оноог заах, шалгалтын явцад текст, хичээлийн тэмдэглэл, тооны машин гэх мэт зүйлс ашиглаж болох эсэх гэх мэт) шалгагч багш нарын баг тогтооно.

4.7.10. Шалгалтын дэг журам (бусдаас хуулах, бусдыг өөрийн нэрээр шалгалтанд оруулах, зөвшөөрөгдөөгүй ном, дэвтэр ашиглах зэрэг) зөрчсөн суралцагчийн шалгалтын материалыг шалгагч багш хураан авч, протокол хөтлөн, F дүн тавьж, ёс суртахууны зөрчил гаргасанд тооцож, уг зөрчил давтагдвал бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргана.

4.7.11. Улирлын явцад хичээлд байнга идэвхтэй оролцсон, тухайн хичээлийн явцын шалгалтын бүх хэлбэрүүдэд амжилттай үнэлэгдсэн, үлгэр жишээч оюутанд уг хичээлийн улирлын шалгалтын үнэлгээг шууд тавихыг үгүйсгэхгүй бөгөөд уг асуудлыг багш суралцагчийн хамт олонд мэдэгдэн, ил тод шийднэ. Шууд дүгнэгдэх суралцагчийн тоо нийт шалгагдах суралцагчийн 10%-аас хэтрэхгүй байвал зохино.

4.8. Дахин судлах хичээлийн үнэлгээ

4.8.1. Заавал судлах хичээлийг судалж, амжилтгүй дүн авсан, мөн “R”, “W”, “U”, “NR” үнэлгээний тэмдэглэгээтэй суралцагч тухайн хичээлийн багц цагийг биелүүлэхийн тулд дахин судална.

4.8.2. Суралцагч хичээлийг судалж, амжилттай үнэлгээ авсан ч тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, үнэлгээгээ ахиулах зорилгоор дахин судалж болно. Суралцах хугацаанд дахин судлах хичээлийн тоо 3 хүртэл байна.

4.8.3. Суралцагч судалж, дүгнэгдсэн хичээлээ дахин судлах тохиолдолд, сургалтын албанад хүсэлтээ гаргаж, сургалтын мэдээллийн системд өмнөх үнэлгээг “R” болгож тэмдэглүүлнэ. “R” үнэлгээ тавиулсан тохиолдолд өмнөх дүнг хүчингүй болгох бөгөөд буцаах боломжгүй.

4.8.4. Суралцагчийн дахин судалсан хичээлийн сүүлчийн үнэлгээ нь албан ёсны дүн болно.

4.8.5. Дипломын хавсралтанд дахин судалсан хичээлийн хувьд суралцагчийн хамгийн сүүлд авсан дүн, багц цагийг бичнэ.

4.9. Хөндлөнгийн шалгалт

4.9.1. Нэг хичээлийг нэгэн ижил нөхцөлд (нэг багшаар заалгаж, шалгуулсан) үзсэн нэг хэсэг, бүлгийн суралцагчийн дүн дараах хэлбэрийн хуваарилалттай байвал хэвийн гэж үзэх ба энэ хуваарилалт зөрчигдвэл багш, суралцагчийн сургах, сурах үйл ажиллагаа зөрчилтэй, хичээлийн хөтөлбөрийг хянан үзэх шаардлагатай эсэх, суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхэд бодитой, шударга хандаагүй зэрэг шалтгааныг сургалтын алба тодруулна. Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шалгалт авч болно.

Үсгээр илтгэсэн дүн	Хувь
A	5-25
A-	
B	15-30
B-	
C	20-40
C-	
D	15-30
D-	
F	0-25

4.9.2. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын шийдвэрээр байгуулсан комисс болон сургалтын нэгдсэн албанаас суралцагчийн судалж мэдлэг, чадвараа шалгуулсан хичээлээр хөндлөнгийн шалгалт зохион байгуулан авч болно.

4.10. Дүнгийн талаарх гомдлыг барагдуулах

4.10.1. Суралцагч хичээлийн дүнгийн гомдолтой бол тухайн хичээлийг судалсаны дараагийн улирлын эхний 1 сар дотор сургалтын албанад хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулж шийдвэрлүүлнэ.

4.10.2. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын шийдвэрээр байгуулсан комисс гомдол гаргасан суралцагчийн шалгалтын материал, уг шалгалтын материалыг үнэлж дүгнэхэд баримталсан зарчим, хэрэглэсэн арга зүй, хэрэглэгдэхүүн (бодлого, тестийн хариу зөв эсэх гэх мэт)-ийг хянан магадлаж, дахин үнэлсний үндсэн дээр зохих дүгнэлтийг гаргана. Хэрэв комиссын дүгнэлтээр шалгалтын материалыг шударга бус үнэлж дүгнэсэн байвал комиссын өгсөн үнэлгээг (суралцагчийн өмнө нь авсан үнэлгээнээс өндөр эсвэл бага байсан ч) эцсийн үнэлгээгээр тооцно.

4.11. Суралцагч чөлөө авах, үргэлжлүүлэн суралцах, сургуулиас чөлөөлөгдөх

4.11.1. Суралцагч чөлөө авах

4.11.1.1. Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар 3 долоо хоногоос дээш хугацаагаар хичээлд сууж чадахгүйд хүрвэл, сургалтын албанд улирлын чөлөө авах тухай хүсэлтээ бичгээр гаргаж сургалтын мэдээллийн системд суралцагчын төлөвийг сургалтын алба өөрчилж сонгосон хичээлийг цуцална.

4.11.1.2. Нэг удаагийн чөлөөний хугацаа 2 хүртэл улирал байж болно.^{90 91 94 95} Чөлөө олгох тухай сургалтын албаны эрхлэгчийн шийдвэрийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна. Суралцагчийн суралцах хугацаанд олгох чөлөөний нийт хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна.

4.11.1.3. Улирлын чөлөөг тухайн улирлын эхнээс тооцож олгоно.

4.11.1.4. Улирлын чөлөө авах тохиолдолд тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг буцааж олгохгүй бөгөөд хичээлийн багц цагийн төлбөрийг энэ журмын 4.5.23-д заасны дагуу зохицуулна.

4.11.1.5. Чөлөө авсан, идэвхгүй төлөвт байгаа суралцагчид улирал бүр суурь үйлчилгээний төлбөрийг төлнө.

4.11.1.6. Суралцагчийн чөлөөтэй байсан хугацааг суралцсан хугацаанд тооцохгүй.

4.11.1.7. Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар 21 хоногоос богино хугацаагаар чөлөө авах бол хүсэлтээ бичгээр (хавсралт 8) гаргаж багшийн зөвшөөрлийг үндэслэн сургалтын алба шийдвэрлэнэ.

4.11.1.8. Суралцагчийн чөлөөний хуудасны загварыг сургалтын нэгдсэн албанаас батална.

4.11.2. Суралцагч үргэлжлүүлэн суралцах

4.11.2.1. Чөлөөний хугацаа дуусахад суралцагч энэ журмын 4.5-д заасны дагуу хичээлд бүртгүүлж, үргэлжлүүлэн суралцах үүрэгтэй.

4.11.2.2. Чөлөөний хугацаа дууссан суралцагч улирлын хичээл эхлэхээс 7-гоос доошгүй хоногийн өмнө үргэлжлүүлэн суралцах өргөдлөө сургалтын албанд өгч шаардлагатай төлбөрийг төлсний үндсэн дээр бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар үргэлжлүүлэн суралцах эрх нээгдэж сургалтын мэдээллийн системд сургалтын алба сургалцагчийн төлвийг өөрчлөнө.

4.11.2.3. Чөлөөний хугацаа дуусч, үргэлжлүүлэн суралцах эрх нь нээгдсэн суралцагч сургалтын алба, тэнхмээс суралцах хувийн төлөвлөгөө зохиох, хичээлд бүртгүүлэх, бусад асуудлаар зөвлөгөө авах шаардлагатай.

4.11.2.4. Улирлын чөлөөг дуусгаад ирсэн болон бусад шалтгаанаар сургалтын хугацаа хойшлон суралцаж байгаа суралцагч сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтөөс болж хичээл, хөтөлбөрийн түвшин, шалгалтын зөрүү гарвал үргэлжлүүлэн суралцах болсон шалтгаан, өмнө нь авч байсан дүнг харгалзахгүйгээр нөхөн үзэх хичээл, өгөх шалгалтыг сургалтын алба, тэнхмийн эрхлэгч/хөтөлбөрийн удирдагч нар хамтран тогтооно.

4.11.2.5. Хоёр улирал дараалан идэвхгүй төлөвт байгаа суралцагч сургалтын албанд үргэлжлүүлэн идэвхтэй төлөвт суралцах хүсэлт гаргах ба идэвхгүй суралцсан хугацааны суурь үйлчилгээний төлбөрийг нөхөн төлнө.

4.11.3. Сургуулиас чөлөөлөгдөх

4.11.3.1. Суралцагч сургуулиас чөлөөлөгдөх тухай хүсэлтийг сургалтын албанад гаргасан тохиолдолд сургуулиас бүрмөсөн чөлөөлөх МУИС-ийн захирлын тушаал гарна.

4.11.3.2. Суралцагчийг дараах шалтгаанаар бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрээр МУИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасна. Үүнд:

- Чөлөөний хугацаа дуусаад хичээлд бүртгүүлээгүй, эсвэл чөлөөг сунгах хүсэлт гаргаагүй,
- 4 улирал сургалт, судалгааны ажилд оролцоогүй,

- Суралцах үлдсэн хугацаанд нийт багц цагийг амжилттай цуглуулах боломжгүй болсон,
- Эзэмшсэн мэдлэг, чадвараа үнэлүүлэхдээ хуурч мэхлэх, дүнгийн тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх зэрэг зөрчил гаргасан,
- Гэмт хэрэг, ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогдсон.

4.11.3.3. Суралцагч сургуулиас хасагдах тохиолдолд өөрт нь албан ёсоор мэдэгдэх ба ямарч төлбөрийг буцааж олгохгүй. Сургуулиас хасагдах нөхцөл бүрдсэн бөгөөд холбоо барих боломжгүй тохиолдолд сургуулиас хасна.

4.12. Төгсөлт

4.12.1. Төгсөлтийн үйл ажиллагаа

4.12.1.1. Төгсөлтийг комисс зохион байгуулна.

4.12.1.2. Төгсөлтийн төв комиссын даргаар сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн даргаар сургалтын нэгдсэн албаны дарга, гишүүнээр бүрэлдэхүүн сургуулийн захирал, салбар хариуцсан дэд захирал, сургалтын нэгдсэн албаны мэргэжилтэн; салбар комиссын даргаар бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн даргаар сургалтын албаны эрхлэгч, гишүүнээр тэнхмийн эрхлэгч, сургалтын албаны мэргэжилтнийг тус тус МУИС-ийн захирлын тушаалаар томилно.

4.12.1.3. Төгсөлтийн төв комисс МУИС-ийн хэмжээнд, салбар комисс тухайн бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд төгсөлтийн үйл ажиллагааг ерөнхий удирдлага, зохицуулалтаар хангана.

4.12.1.4. Төгсөлтийн төв болон салбар комисс төгсөлт дууссаны дараа тайлан бичиж, сургуулийн захиргаанд өгөх бөгөөд бэлтгэж байгаа мэргэжилтний чанарын түвшин, сургалтын агуулга, технологийн талаар дүгнэлт өгч, цаашид анхаарах арга хэмжээний талаар тодорхой санал, зөвлөмж оруулсан байвал зохино.

4.12.2. Төгсөгчдөд тавих шаардлага

4.12.2.1. Төгсөгч нь МУИС-д зохих журмын дагуу захирлын тушаалаар элссэн байна.

4.12.2.2. Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх тус журмын 3.6.2-д заасан багц цагийн хувиарлалтыг биелүүлж, 120-оос доошгүй багц цаг цуглувансан, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн оюутанд дээд боловсролын бакалаврын зэрэг олгож төгсгөнө.

4.12.2.3. Бакалаврын хөтөлбөрийн төгсөгч нь англи хэлний ахисан дунд (upper intermediate) түвшний мэдлэг эзэмшсэн байх бөгөөд TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний онооноос дээш оноотой эсвэл МУИС-ийн гадаад хэлний төвийн шалгалтаар амжилттай дүгнэгдсэн бол шаардлага хангасан гэж үзнэ. Ахисан дундаас дээш түвшний англи хэлний хичээлийг МУИС дээр судалсан бол англи хэлний шалгалт өгөх шаардлагагүй, болзол хангасан гэж үзнэ.

4.12.2.4. Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийг бүрэн, мөн мэргэжлийн зарим хичээлүүдийг судалж 90-ээс (ХЗС 120) доошгүй багц цаг цуглувлан, хүндэтгэх шалтгааны улмаас төгсөх хүсэлт гаргасан оюутанд дээд боловсролын дипломын зэрэг олгож болно. Дипломын зэргээр төгсөгч нь төгссөнөөсөө хойш 3 жилийн дотор тухайн мэргэжлээр элсэлтийн шалгалтгүйгээр үргэлжлүүлэн суралцаж, багц цагаа амжилттай судалж гүйцээн журмын дагуу бакалаврын зэрэг авч болно.

4.12.2.5. Төгсөгч хавсарга эсвэл хос мэргэжлээр суралцах тохиолдолд сургууль/салбар, мэргэжлийн тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн байна. Хос мэргэжлээр амжилттай суралцсан оюутанд давхар суралцсан мэргэжлийн хоёр дахь бакалаврын диплом олгоно.

4.12.2.6. Магистрын ажлын хамгаалалтын өмнөх хэлэлцүүлгийг тэнхмийн эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинарт хийнэ. Өргөтгөсөн семинараас дүгнэлт гаргаж,

хуралдааны протоколын хамт бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанад хүргүүлнэ. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ.

4.12.2.7. Магистрын ажлыг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална. Зэрэг хамгаалуулах зөвлөлийг мэргэжлийн тэнхмийн саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар байгуулна.

4.12.2.8. Магистрант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, гадаад хэлний шалгалтаа өгсөн, магистрын ажлаа тэнхимд урьдчилан хэлэлцүүлсэн тухай тэнхмийн дүгнэлтийг үндэслэн, магистрын зэрэг хамгаалуулахыг зөвшөөрсөн тухай бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаал гаргаж, магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжилна.

4.12.2.9. Магистрын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийг бүрэн судалж, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн, мэргэжлийн магистрын хувьд 32, судалгааны магистрын хувьд 30-аас доошгүй багц цуглуулсан суралцагчийг дээд боловсролын магистрын зэргээр төгсгөне.

4.12.2.10. Докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, докторын зэрэг горилсон диссертацийн ажлаа тэнхим, бүрэлдэхүүн сургууль/салбар, мэргэжлийн эрдэмтэдийн өргөтгөсөн семинарт урьдчилан хэлэлцүүлсэн тухай дүгнэлт гарган докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжилна. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ. Семинараас диссертацид мэргэжлийн дүгнэлт хийж, хуралдааны протокол гаргах ба энэ нь докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд МУИС-иас гаргаж өгөх дүгнэлтийн нэг үндэслэл болно.

4.12.2.11. Докторын диссертацийг монгол хэлээр бичнэ. Диссертацийн тухай товч танилцуулгыг англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, диссертацийн эцэст хавсаргана. Горилогчийн хүсэлт, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн дийлэнх олонхийн зөвшөөрснөөр диссертацийн ажлыг англи хэлээр бичүүлж, хамгаалалтыг англи хэлээр явуулж болно. Энэ тохиолдолд диссертацийн тухай товч танилцуулгыг монгол хэлээр бичнэ.

4.12.2.12. Бакалаврын судалгааны ажил, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг захирлын тушаалаар батлагдсан загварын дагуу бичиж, хэвлүүлнэ.

4.12.2.13. Докторын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийг бүрэн судалж, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн, 60-аас доошгүй багц цуглуулсан, докторын диссертация амжилттай хамгаалсан суралцагчийг дээд боловсролын докторын зэргээр төгсгөнэ.

4.12.2.14. Бакалаврын зэрэг горилогчийн суралцсан хугацааны голч дүн 1.8 ба түүнээс их, магистр, докторын зэрэг горилогчийн суралцсан хугацааны голч дүн 2.3 ба түүнээс их байна.

4.12.2.15. Төгсөгч нь сургалтын төлбөрийн болон бусад тооцоогүй байна.

4.12.3. Төгсөх хүсэлт гаргах, хүсэлтийг хянан магадлах

4.12.3.1. Төгсөлт жилд хоёр удаа хавар, намрын улиралд явагдана.

4.12.3.2. Төгсөгчид тавих шаардлагыг бүрэн биелүүлэх боломжтой суралцагч төгсөх хүсэлтээ сургалтын мэдээллийн системээр дамжуулан төгсөх улирлын 6-10 дугаар долоо хоногт багтааж сургалтын албанад гаргана.


4.12.3.3. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлт гаргах хугацаанаас хоцорсон суралцагчийн төгсөх тухай асуудлыг сургалтын албаны саналыг үндэслэн төгсөлтийн салбар комисс шийдвэрлэнэ.

4.12.3.4. Сургалтын алба тухайн суралцагчийн харьялагдан суралцаж байгаа үндсэн мэргэжлийн тэнхим/салбартай хамтран төгсөх хүсэлтийг нь хянаж үзнэ. Улмаар төгсөх боломжтой гэдгийг нь төгсөлтийн үйл явц, ёслолын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хамт, эсвэл төгсөхөд дутуу хангагдсан байгаа шаардлагуудын талаар суралцагчид мэдэгдэнэ.

4.12.3.5. Суралцагч төгсөх хүсэлт гаргасан улиралдаа төгсөж чадаагүй бол төгсөх тухай хүсэлтийг дараагийн улиралд дахин гаргаж болно.

4.12.3.6. Төгсөлтийн салбар комисс тухайн улиралд төгсөх суралцагчийн нэрсийн жагсаалтыг төгсөлтийн төв комисст төгсөх улирлын 10 дугаар долоо хоногт ирүүлнэ.

4.12.3.7. Сургалтын алба тухайн улиралд төгсөх суралцагчийн нэрс гаргаж бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.



4.12.4. Төгсөлтийн бичиг баримт

4.12.4.1. Энэхүү журмын дагуу амжилттай сурч, дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзول хангасан суралцагчийн төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн, МУИС-ийн захирлын тушаалаар төгсгөн, мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдэг олгоно.

4.12.4.2. Бакалаврын зэргийн диплом нь МУИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн захирал, төгсөлтийн ерөнхий комиссын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, МУИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба дугаар, бүртгэлийн дугаартай байна.

4.12.4.3. Магистр, докторын зэргийн диплом нь МУИС-ийн удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн захирал, хамгаалуулах зөвлөлийн дарга, төгсөлтийн дараах сургуулийн захирлын гарын үсэг, МУИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба (мэргэжлийн магистрын хувьд хамгаалуулах зөвлөлөөр орохгүй тул даргын гарын үсэг шаарлагагүй) дугаар, бүртгэлийн дугаартай байна.

4.12.4.4. Диплом хавсралттай байх ба хавсралтанд эзэмшсэн үндсэн болон хавсарга мэргэжил, гүнзгийрэн судалсан чиглэл, суралцах хугацаанд амжилттай судалсан хичээлүүд, тэдгээрийн багц цаг, голч дүн ба оноог бичихээс гадна эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт нийцүүлэн бусад бичиглэлийг хийж болно. Хавсралтыг МУИС-ийн сургалтын нэгдсэн албаны дарга болон сургалтын албаны эрхлэгчийн гарын үсэг, тамга/тэмдгээр баталгаажуулна.

4.12.4.5. Диплом, хавсралтын загварыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4.12.4.6. Үндсэн чиглэлээсээ гадна хавсарга мэргэжлээр суралцсан тохиолдолд боловсролын давхар зэрэг, диплом олгохгүй.

4.12.4.7. Бакалаврын оюутны хувьд суралцах дээд хугацаанд судалбал зохих хичээлийг бүрэн судалсан ч суралцсан хугацааны голч дүн 1.8-аас доош оюутанд МУИС-ийн тухайн мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан бүх хичээл судалсаныг гэрчилсэн тусгай бичиг баримт олгож болно.

4.12.4.8. Магистрант, докторант сургалтын багц цагаа хугацаандаа цуглувансан боловч магистрын ажил, диссертаци бичих багц цагаа биелүүлж амжаагүй бол МУИС-ийн магистр/докторын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаал гаргаж, гэрчилгээ олгоно. Магистрант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 3 жил, докторант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 5 жил хүчинтэй байх ба энэ хугацаанд эрдэм шинжилгээний багц цагаа гүйцээн магистрын ажил, докторын диссертаци бичиж хамгаалах эрхтэй байна.

4.12.4.9. Төгсөлтийн салбар комисс сургуулийн архивт төгсөж байгаа суралцагчтай холбоотой дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр (загварыг сургалтын төв албанаас гарган мөрдүүлнэ)
- Төгсөгчдөд диплом олгосон бүртгэлийн хуулбар (мэргэжлийн хөтөлбөрөөр)
- Хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол
- Удирдагчийн тодорхойлолт
- Суралцсан хугацааны тодорхойлолт
- Дипломын хуулбар
- Сурлагын дунгийн эх хувь (дипломын хавсралт) -1 ширхэг

- Дэлгэрэнгүй анкет (1-р маягт)
- Суралцагчийн үнэмлэх
- Тойрох хуудас

4.12.4.10. Магистрын ажил, диссертацийг үндэсний номын сан мэдээллийн технологийн үндэсний парк, сургуулийн номын санд хүлээлгэн өгнө.

4.12.4.11. Төгсөлтийн бичиг баримтын эх хувийг цахим хэлбэрээр шалгах боломжтой байна.

4.12.4.12. Төгсөлтийн баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд архивын материалыг үндэслэн зөвхөн дипломыг нөхөн олгох бөгөөд үүнийг тусгай журмаар зохицуулна. Харин комиссын буруутай үйл ажиллагааны улмаас диплом дахин олгох асуудлыг тухайн үед мөрдөгдөж буй дүрэм, журамд нийцүүлэн төгсөлтийн хугацаанд шийдвэрлэнэ.

4.12.4.13. Төгсөгч төгсөлтгэй (диплом, энгэрийн тэмдэг, дипломын хавтас, ёслолын хувцас гэх мэт) холбоотой хураамж төлнө.

4.12.4.14. Төгсөлтийн баримт бичгийг засварлах буюу хуурамчаар үйлдвэл буруутай этгээд хуулийн хариуцлага хүлээнэ.

4.12.5. Төгсөлтийн ёслол

4.12.5.1. Төгсөгчдөд МУИС-ийн диплом, энгэрийн тэмдгийг ёслолын байдалд хүндэтгэлтэйгээр гардуулна. Энэ ёслолын үед МУИС-ийн захирлын тушаалыг уншиж сонсгоно.

4.12.5.2. Төгсөлтийн ёслолын арга хэмжээнд төгсөгчид, тэдгээрийн найз нөхөд, эцэг эхийн төлөөллийг оролцуулан эрдмийн баяр болгон тэмдэглэнэ.

4.13. Сургалтын төлбөр

4.13.1. Сургалтын төлбөр нь судлах хичээлийн багц цагийн төлбөр, суурь үйлчилгээний төлбөрөөс бүрдэнэ. Сургалтын төлбөрийг суралцагч улирал бүр төлнө.

4.13.2. Суурь үйлчилгээний төлбөр нь МУИС-ийн суралцагчийн суралцах эрхийг хадгалах, нийтлэг үйлчилгээтэй холбоотой зардлаас бүрдэнэ. Энэ нь эрдмийн хамт олон багш профессор, бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн оюутнуудад үзүүлдэг төвлөрсөн үйлчилгээ, номын сан (ном бүрдүүлэлт, олон улсын сэтгүүлийн онлайн эрх, номын сан болон оюутны бие даах төвийн ажилтны цалин хөлс, мэдээлэл, програм хангамж)-ийн үйлчилгээ, сургалтын үйл ажиллагаатай холбогдсон нэгдсэн үйлчилгээ, захиргаа, удирдлагын зардлын тодорхой хувь хэмжээ, оюутны байгууллага, клубын зардал, сургалтын орчинг сайжруулах (хангамж үйлчилгээний алба, үйлчилгээний ажилчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, МУИС-ийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламж, оюутны болоод хичээлийн анги танхмийн их ба урсгал засвар, сурх орчны тохижилт, сургалт, судалгаа болоод бусад тоног төхөөрөмжийн элэгдэл), оюутны мэдээллийн үйлчилгээ (оюутны гарын авлага, холбогдох мэдээлэл, мэдээлэл технологийн үйл ажиллагааны төсөв, сургалтын мэдээллийн системийн үйл ажиллагаа, програм хөгжүүлэлт, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл) зэргийг санхүүжүүлнэ.

4.13.3. Багц цагийн төлбөр нь сургалттай холбоотой шууд зардлаас бүрдэнэ. Энэ нь оюутны сурх үйл ажиллагаанд шууд холбоотой сургалтын үйлчилгээ бөгөөд багш профессорууд, салбар сургалтын албадын мэргэжилтэн, зааварлагчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, хээрийн болон үйлдвэрлэлийн дадлага, сургалтын үйлчилгээний ажилчдын цалин хөлс, хичээл практик, эрдэм шинжилгээний хурал семинарын зардал, оюутны академик үйлчилгээ, оюутны тэтгэлэг, олимпиад, оюутны дунд зохиогддог бүх төрлийн уралдаан тэмцээний зардал, гадаад багш болон багшийн үйл ажиллагаа, хөгжлийг дэмжих зардал, интернет, сургалтын тоног төхөөрөмж, эд хогшлын зардал зэргийг санхүүжүүлнэ.

4.13.4. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлын багц цагийн төлбөр нь лаборатори, судалгааны тоног төхөөрөмжийн зардал, лабораторийн ажилтны зардал,



эрдэм шинжилгээний хурал, семинарын зардал, магистрант, докторантын судалгааны ажлын хэлэлцүүлэг, санал, зөвлөмж өгсөн эрдэмтдийн ажлын хөлс зэргийг санхүүжүүлнэ.

4.13.5. Багц цагийн төлбөр нь бүрэлдэхүүн сургууль, салбар, хөтөлбөр, түвшингээрээ өөр өөр байж болно.

4.13.6. Хос, хавсарга хөтөлбөрөөр суралцах оюутан сургалтын багц цагийн төлбөрийг тухайн хос, хавсарга хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүрэлдэхүүн сургуульд, үндсэн мэргэжлийн сургалтын багц цагийн төлбөрийг суурь ~~ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН~~ хамт үндсэн мэргэжлээр суралцаж буй сургуульд төлнө. Хос, хавсарга мэргэжлээр суралцагч нь суурь үйлчилгээний төлбөрийг давхар төлөхгүй.

4.13.7. Нөхцөлтэй элсэн суралцагч нь бакалаврын түвшний хичээл судалбал бакалаврын түвшний багц цагийн төлбөр, магистрын түвшний хичээл судалбал магистрын багц цагийн төлбөр төлнө.

4.13.8. Оюутан магистрын түвшний хичээл судалбал магистрын түвшний багц цагийн төлбөр, магистрант докторын түвшний хичээл судалбал докторын багц цагийн төлбөр төлнө. Магистрант, докторант нь өөр өөрийн хөтөлбөрт заасан хичээлийг хамтдаа судалбал өөр өөрийн түвшний багц цагийн төлбөр төлнө.

4.13.9. Суралцагчийн дүйцүүлсэн багц цагийн төлбөрийг авахгүй.

4.13.10. Суралцагч сургалтын төлбөрөөс гадна төгсөлт, дотуур байр болон бусад нэмэлт үйлчилгээтэй холбоотой төлбөр, хураамжийг тухай бүр төлнө.

4.13.11. Зохих шалгуур хангасан суралцагч нь байгууллага, хувь хүн олгодог сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулалд хамрагдах боломжтой.

4.13.12. Хичээлийн багц цагийн төлбөр, улирлын үйлчилгээний төлбөрийн хэмжээг жил бүр шинэчлэн тогтоож, МУИС-ийн Удирдах зөвлөл батлах ба тухайн хичээлийн жилийн хугацаанд өөрчлөхгүй.

4.13.13. Энэ журмын хүрээнд суралцагчаас авах сургалтын үйлчилгээтэй холбоотой төлбөр, хураамжийн хэмжээг санхүү, эдийн засгийн хэлтсээс боловсруулж хичээлийн жил эхлэхээс өмнө МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулан мөрдүүлнэ.

4.13.14. МУИС-ийн бакалаврын түвшний хичээл судалсан иргэд суурь үйлчилгээний төлбөр болон 1-р түвшний оюутнуудын суралцах багц цагийн төлбөрийг төлнө.


4.14. Сургуулиас олгох албан бичиг баримт, лавлагаа

4.14.1. МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд суралцагчаар элсүүлэх тухай захирлын тушаал гарсны дараа элссэн суралцагчдад суралцагчийн үнэмлэхийг үнэ төлбөргүй олгоно. Үнэмлэхээ гээсэн, үрэгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд зохих төлбөрийг төлж нөхөн авч болно.

4.14.2. Энэхүү журмын дагуу амжилттай сурч, дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзол хангасан суралцагчийг төгсөхөд тухайн боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх баримт бичиг, энгэрийн тэмдэг олгоно. Дипломын хавсралт дахь дүнгийн жагсаалтад суралцагчийн хангалтгүй судалсан хичээлийн дүнг оруулахгүй.

4.14.3. Суралцагчийн лавлагаа, тодорхойлолтын загварыг сургалтын нэгдсэн албанаас батлах бөгөөд дараах хугацаанд олгоно.

Бичиг баримтын нэр, төрөл	Олгох алба	Хугацаа
МУИС-ийн суралцагч мөн болох тухай, дүнгийн албан ёсны тодорхойлолт	Сургалтын алба	Ажлын 1 хоногт
	ТҮЦ машин	Тухай бүр
Суралцаж байсан үеийн дүнгийн албан ёсны тодорхойлолт	Сургалтын алба	Ажлын 3 хоногт

Төгссөн тухай тодорхойлолт, дипломын хавсралт дахь дүнгийн албан ёсны магадллагаа	Сургалтын нэгдсэн алба	Англи хэл дээр бол ажлын 3, монгол хэл дээр бол ажлын 1 хоногт 
Суралцагчийн үнэмлэх хаяж гээгдүүлсэн тохиолдолд нөхөн авах	Сургалтын нэгдсэн алба	Ажлын 5 хоногт  УХД0072 9104399
Диплом нөхөн олгох	Сургалтын нэгдсан алба	Ажлын 10 хоногт

4.14.4. Албан бичгийг ТҮЦ машинаас суралцагч хичээлийн жилд хоёр удаа үнэ төлбөргүй, давтан авах бол тодорхой хураамж төлж авах ба ТҮЦ машинаас гарсан албан бичиг нь хичээлийн жилийн тухайн улиралдаа хүчин төгөлдөр, сургалтын албанаас гаргах албан бичигтэй эрх зүйн хувьд адил байна. ТҮЦ машинтай холбоотой бусад асуудлыг тусдаа журмаар зохицуулна.

4.14.5. Албан ёсны бичиг баримтыг олгоходо тухайн суралцагч, төгсөгчид өөрт нь өгөх бөгөөд өөрөө ирж авах боломжгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгоно. Үүнээс бусад тохиолдолд өөр хүнд өгөхийг хориглоно.

4.14.6. Албан ёсны бичиг баримтыг олгоходо холбогдох журамд заасан зохих хэмжээний хураамж авна.

4.15. Журмын хэрэгжилтийн хяналт, үнэлгээ

4.15.1. Энэ журмын хэрэгжилтэд сургалтын нэгдсэн алба, сургалтын алба тогтмол хяналт тавьж, үнэлгээ хийн, үр дүнг нь сургалтанд оролцогч талуудад мэдээлж, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад ашиглана.

4.15.2. Журмын хэрэгжилтийн хяналт, үнэлгээг МУИС-ийн бүтцийн болон бусад нэгжүүдээс тогтмол болон тогтмол бус хугацаанд гаргадаг сургалтын бичиг баримт, тайлан, судалгаа, суралцагч, багш, ажилтан, төгсөгч, ажил олгогчдыг хамруулсан санал асуулга, хөндлөнгийн шалгалтын дүн зэрэгт тулгуурлан хийнэ.

Хавсралт 1

УХД0072 0104399

Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх аргачлал.

Тухайн хичээлээр суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа дараах аргачлалыг баримтлана.

$$O = O_1 + O_2 + O_3$$

Үүнд:

O₁ - Идэвх, оролцооны үнэлгээ. Хичээлд оролцсон бүтээлч ирц, семинар, дадлагын хичээлд бэлтгэсэн байдал зэрэгт багшийн өгсөн үнэлгээ бөгөөд 20-40 оноо байна.

O₂ - Суралцагчийн явцын үнэлгээ. Улирлын явцад хийсэн илтгэл, реферат, тайлан, хяналтын ажил, коллеквиум, сэдвийн үнэлгээний дундаж болон явцын шалгалтын нийлбэр бөгөөд 20-40 оноо байна.

O₃ - Улирлын шалгалтын үнэлгээ бөгөөд 20-60 оноо байна.

Тайлбар:

- Суралцагчийн ирц, идэвх оролцоог бүртгэн үнэлэх боломж хязгаарлагдмал хичээлийн хувьд тэнхим хэлэлцэж, O₁ оноог хамгийн бага боломжит хэмжээнд тогтоож болно.
- Хичээл бүрийн хөтөлбөрт тухайн хичээлээр суралцагчийн олж авсан мэдлэг, чадварыг үнэлэх онооны хуваарилалтыг хэдэн ч хэсгээр хийсэн байж болох ба багши түүнийг баримтлана.
- O₁, O₂, O₃ үнэлгээ нь бүхэл тоон нарийвчлалтай байна.

Хавсралт 2

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШАЛГАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

20... – 20... оны хичээлийн жил, намрын/хаврын улирал

Бүрэлдэхүүн сургуулийн нэр:

Хичээлийн нэр:

Индекс:

Кредит:

№	Суралцагчийн үнэмлэхний дугаар	Суралцагчийн овог	Суралцагчийн нэр	Хэсэгчилсэн оноо			Ерөнхий Үнэлгээ О	Дүн тавьсан огноо
				Илдэвх О ₁	Явчны Үнэлгээ О ₂	Шалгалт О ₃		
Дүгнэсэн багш:								
Хөтөлбөр:								
1								
2								
3								
Гарын үсэг: / /								

Шалгалтыг хичээлийн ...-р байрны тоот өрөөнд 20.... оны ...-р сарын ...-ний өдөр авав.

Шалгагдвал зохих- ..., өвчтэй-..., чөлөөтэй- ..., ороогүй-

A=..., A-=..., B=..., B-=..., C=..., C-=..., D=..., D-=..., F=..., I=..., E=..., R=..., W=..., CR=..., NC=..., NR=..., S=..., U=.... .

Хүлээлгэн өгсөн огноо:.....

Хүлээн авсан:

**“R” ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ ГАРГАХ (ХИЧЭЭЛ
ДАХИН СУДЛАХ) МАЯГТ**



Суралцагчийн овог, нэр:
 Суралцаж байгаа хөтөлбөр:
 Хувийн дугаар /ID/:
 Утасны дугаар:
 И-мэйл:

№	“R” үнэлгээнд шилжүүлэх хичээлийн нэр	Өмнө нь судалж дүгнэгдсэн улирал	Хичээл заасан багшийн нэр	Тухайн үед дүгнэгдсэн оноо	Дүн ахиулж судлах улирал
1.					
2.					
3.					

**Суралцагч та энэхүү хүсэлтийг гаргахаас өмнө дараах журмыг
анхааралтай унишж танилцана уу.**

Сургалтын исурмаас...

4.8.3 Суралцагч судалж, дүгнэгдсэн хичээлээ дахин судлах тохиолдолд, сургалтын албанад хүсэлтээ гаргаж, сургалтын мэдээллийн системд өмнөх үнэлгээг “R” болгож тэмдэглүүлнэ. “R” үнэлгээ тавиулсан тохиолдолд өмнөх дүнг хүчингүй болгох бөгөөд буцаах боломжгүй.

4.8.4 Суралцагчийн дахин судалсан хичээлийн сүүлчийн үнэлгээ нь албан ёсны дүн болно.

4.8.5 Дипломын хавсралтандаа дахин судалсан хичээлийн хувьд суралцагчийн хамгийн сүүлд авсан дүн, багц цагийг бичнэ.

Суралцагчийн хүсэлт гаргасан огиоо: 20... оны сарын өдөр

Суралцагчийн гарын үсэг:

Хүсэлтийн хариу тайлбар, шийдвэр:

.....
.....
.....

**ДҮНГИЙН МАРГААН, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ
ХҮСЭЛТИЙН МАЯГТ**

УХД0072 9104399

Суралцагчийн овог нэр:

Суралцаж байгаа хөтөлбөр:

Хувийн дугаар /ID/:

Утасны дугаар:

И-мэйл:

Хугацаандaa дүгнэгдээгүй шалтгаан:

№	Хичээлийн нэр	Багц цаг	Судалсан улирал	Дүн	Багшийн гарын үсэг	Огноо
1.						
2.						
3.						
4.						
5.						

Суралцагч та энэхүү хүсэлтийг гаргахаас өмнө дараах журмыг анхааралтай унишж танилцана уу.

Сургалтын жсурмаас...

4.10 Дунгийн талаарх гомдолыг барагдуулах

- 4.10.1** Суралцагч хичээлийн дүнгийн гомдолтой бол тухайн хичээлийг судалсны дараагийн улирлын эхний 1 сар дотор сургалтын албанад хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулж шийдвэрлүүлнэ.
- 4.10.2** Бүрэлдэхүүн сургуулийн захирлын шийдвэрээр байгуулсан комисс гомдол гаргасан суралцагчийн шалгалтын материал, уг шалгалтын материалыг үнэлж дүгнэхэд баримталсан зарчим, хэрэглэсэн арга зүй, хэрэглэгдэхүүн (бодлого, тестийн хариу зөв эсэх гэх мэт)-ийг хянан магадалж, дахин үнэлсний үндсэн дээр зохих дүгнэлтийг гаргана. Хэрэв комиссын дүгнэлтээр шалгалтын материалыг шударга бус үнэлж дүгнэсэн байвал комиссын өгсөн үнэлгээг (суралцагчийн өмнө нь авсан үнэлгээнээс өндөр эсвэл бага байсан ч) эцсийн үнэлгээгээр тооцно.

Суралцагчийн хүсэлт гаргасан огноо: 20.... оны сарын өдөр

Суралцагчийн гарын үсэг:

Хүсэлтийн хариу тайлбар, шийдвэр:

.....
.....
.....

**ХОЖИМДСОН БҮРТГЭЛ ХИЙЛГЭХ
ХҮСЭЛТИЙН МАЯГТ**

Суралцагчийн овог, нэр:
 Суралцаж байгаа хөтөлбөр:
 Хувийн дугаар /ID/:
 Утасны дугаар:
 И-мэйл:



№	Бүртгүүлэх хичээлийн иэрс	Багц цаг	Бүртгэл хийлгэх улирал	Хичээл заах багшийн нэр	Судалж буй хичээлийн гараг, цаг
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					

Суралцагч та энэхүү хүсэлтийг гаргахаас өмнө дараах журмыг анхааралтай уншиж танилцана уу.

4.5. Хичээл, хичээлд бүртгүүлэх

- 4.5.22** Хүндэтгэн үззх шалтгаанаар заасан хугацаанд хичээлдээ бүртгүүлж амжаагүй суралцагч тухайн улирлын эхний 7 хоногт багтан бүртгүүлэх боломжтой хичээлд бүртгэлийн хураамж төлж бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь тухайн хичээлийн 1 багц цагийн төлбөртэй дүйцэхүйц байна.
- 4.5.9** Бакалаврын өдрийн хөтөлбөрийн хувьд оюутан улиралд дунджаар 15 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн доод хэмжээ 12, дээд хэмжээ 21 байна.
- 4.5.10** Магистрын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 12 (ХЗС 13) байна. Докторын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 (эчнээ 6) багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 15 (ХЗС 13) байна.

Суралцагчийн гаргасан огноо: 20.... оны сарын өдөр

Суралцагчийн гарын үсэг:
 Хүсэлтийн хариу тайлбар, шийдвэр:

ХИЧЭЭЛ ЦУЦЛУУЛАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ



Суралцагчийн овог, нэр:
 Суралцаж байгаа хөтөлбөр /Анги/:
 Хувийн дугаар /ID/:
 Утасны дугаар:
 И-мэйл:

№	Цуцлуулах хичээлийн нэр	Багц цаг	Цуцлалт хийлгэх улирал	Хичээл зааж буй багшийн нэр	Судалж буй хичээлийн гараг, цаг
1					
2					
3					
4					
5					

Суралцагч та энэхүү хүсэлтийг гаргахаас өмнө дараах журмыг анхааралтай уншиж танилцана уу.

4.5 Хичээл, хичээлд бүртгүүлэх

- 4.5.17** Хичээлийг сонгон бүртгүүлснээс хойш 24 цагийн дотор төлбөрөө төлөн баталгаажуулна. Баталгаажуулаагүй хичээлийг цуцална. Хэрэв тухайн хичээлийг судлах оюутны тоонд багтахгүй бол хүлээлгийн жагсаалтанд нэрээ бүртгүүлж болно.
- 4.5.18** Суралцагч баталгаажуулсан хичээлийг хичээлд бүртгүүлэн, баталгаажуулах хугацаанд өөрөө цуцалж болно.
- 4.5.20** Анги бүрдээгүй тохиолдолд сонгон суралцах хичээл бол өөр ижил төстэй хичээлийг санал болгох, мэргэжлийн заавал үзэх хичээл бол тэнхим, сургалтын албаны саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөл шийдвэрлэнэ.
- 4.5.23** Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн 70 хувийг дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Хичээлийн цагийн 30-ас дээш хувь өнгөрсөн бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй. Аль ч тохиолдолд тухайн улирлын суурь үлчилгээний төлбөрийг буцааж олгохгүй.

Суралцагчийн хүсэлт гаргасан огноо:

20.... оны сарын өдөр

Суралцагчийн гарын үсэг:

Хүсэлтийн хариу тайлбар, шийдвэр:.....

.....
.....
.....

**ЧӨЛӨӨТ СОНГОЛТЫН ХИЧЭЭЛ НЭМҮҮЛЭХ
ХҮСЭЛТИЙН МАЯГТ**



Суралцагчийн овог, нэр:
 Суралцаж байгаа хөтөлбөр:
 Хувийн дугаар /ID/:
 Утасны дугаар:
 И-мэйл:

№	Чөлөөт сонголтод нэмүүлэх хичээлийн нэр	Индекс	Багц цаг	Улирал	Хичээл харьяалагдах сургууль
1					
2					
3					
4					
5					

Суралцагч та энэхүү хүсэлтийг гаргахаас өмнө дараах журмыг анхааралтай уншиж танилцана уу.

- 4.5.15** Суралцагч хичээлийн хуваарийг үндэслэн улирал эхлэхээс өмнөх долоо хоногт хичээлд бүртгүүлэх ба бүртгүүлсэн хичээлийн багц цагийн төлбөр, тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг цахим хэлбэрээр төлж, баталгаажуулна.

Суралцагчийн хүсэлт гаргасан огноо: 20.... оны сарын өдөр

Суралцагчийн гарын үсэг:

Хүсэлтийн хариу тайлбар, шийдвэр:.....

.....
.....
.....

Хүсэлтийг хүлээн авч, хариу олгосон: 20.... оны сарын өдөр

ОЮУТАНД ЧӨЛӨӨ ОЛГОХ ХУУДАС

20, оны сарын өдөр

УХД0072 9104399

Суралцагч ийн овог нэр, хүйс					
Элссэн тушаал, оюутны дугаар					
Суралцаж буй хөтөлбөр	Физик				
Түвшин	1	2	3	4	Гарын үсэг:
Сурлагын дүн, багц цагийн мэдээ: Сургалтын албаны ажилтан					
Чөлөө авах шалтгаанаа бичнэ үү					
Номын сан /......./					
Номын сан /......./					
Чөлөө олгохыг зөвшөөрөх эсэх: /Сургалтын алба/					
Сургалтын төлбөрийн тооцоотой эсэх: /Бүрэлдэхүүн сургуулийн нягтлан бодогч					

Суралцагч та энэхүү хүсэлтийг гаргахаас өмнө дараах журмыг
анхааралтай уншиж танилцана уу.

4.11 Суралцагч чөлөө авах, үргэлжлүүлэн суралцах, сургуулиас чөлөөлөгдөх

4.11.1 Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар 3 долоо хоногоос дээш хугацаагаар хичээлд сууж чадахгүйд хүрвэл, сургалтын албанд улирлын чөлөө авах тухай хүсэлт бичгээр гаргаж сургалтын мэдээллийн системд суралцагчийн төлөвийг сургалтын алба өөрчилж сонгосон хичээлийг цуцлана.

4.11.2 Нэг удаагийн чөлөөний хугацаа 2 хүртэл улирал байж болно. Чөлөө олгох тухай сургалтын албаны эрхлэгчийн шийдвэрийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна. Суралцагчийн суралцах хугацаанд олгох чөлөөний нийт хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна.

* * *

* * *

* * *